

"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО" НИЙТЛЭЛИЙН БҮТЭЭЛ БОЛОХЫГ
ТҮҮНИЙ БИЧЛЭГИЙН ЗАРИМ АРГА ХЭЛБЭРЭЭР
ТОДОТГОН БАТАЛГААЖУУЛАХ НЬ

Т.Баасансүрэн*

* "Улаанбаатар-Эрдэм" их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), профессор

Түлхүүр үг: "Монголын нууц товчоо", уран зохиолын дурсгалт бичиг, уран зохиолын дурсгалт бичиг, баримтат бичлэгийн хэв загвар

“Монголын нууц товчоо”-г Монголын уран зохиолын дурсгалт бичиг, монгол хэлний болоод түүх бичлэгийн үнэт эх сурвалж бичиг мөнийг академич Ц. Дамдинсүрэн гуай анх дэвшүүлэн тавьж баталж ихэд дэлгэрэнгүйгээр судалж өргөн олон уншигчдад танилцуулсан билээ (Монголын уран зохиолын түүх, 1956). Түүнийг нь дотоод гадаадын олон эрдэмтэд хүлээн зөвшөөрдөг төдийгүй “Монголын нууц товчоо”-г янз бүрийн өнцгөөс дэлгэрүүлэн авч үзэж судалсан байдаг.

Харин “Монголын нууц товчоо”-г нийтлэлийн бүтээл болохыг тодотгож, эл хөлгөн их сударт сэтгүүл зүйн бичлэгийн элементүүд тодорхой хэмжээгээр агуулагдаж буйг авч үзэж судлах оролдлого хийсэн нь бүр сүүлд буюу хоёр мянган оны эхэн үед хамаарна. МУСГЗ, сэтгүүлч Хорлоогийн Цэвэлзэ гуай “Миний сэтгүүл зүй II” (2010) номондоо “Монголын нууц товчоо”-нд байгаа баримтат бичлэгийн хэв загварт анализ хийж үзжээ. Улмаар

“Монголын шилдэг нийтлэл” цуврал 99 ботийн 59 дэх дугаарыг өөрийн бүтээлээр гаргахдаа тэдгээр нийтлэлээ бүрэн эхээр нь оруулсан байна. Х. Цэвэлзэ сэтгүүлч “Монголын нууц товчоо”-нд байгаа баримтат бичлэгийн хэв загварыг “Удиртгал мэдээлэл”, “Мэдээ маягийн бичлэг”, “Сурвалжлага маягийн бичлэг”, “Тэмдэглэл маягийн бичлэг”, “Өөрийн яриа буюу өгүүлэл”, “Сурвалжилсан тэмдэглэлийн хэлбэрээр” гэх зэргээр дотор нь зургаа ангилж үзжээ.

“Монголын шилдэг нийтлэл” цуврал 99 ботийн 59 дэх ботийн 4 дүгээр бүлэг нь бүхэлдээ “Монголын нууц товчоо”-нд зориулагджээ. Энэ бол 2010 онд хэвлэгдсэн “Миний сэтгүүл зүй” бүтээлийнх нь хоёрдугаар дэвтэр юм. “Монголын нууц товчоо”-нд байгаа баримтат бичлэгийн загвар гэж тэрбээр гарчиглаад:

- Мэдээний загвар
- Сурвалжлагын загвар
- Тэмдэглэлийн загвар
- Өгүүллийн загвар
- Дуртгалын загвар гэж тус тусад нь тодотгосон байна.

Эдгээртэй нэг бүрчлэн танилцаж санал нийлэх ба нийлэхгүй зүйлээ

илэрхийлэн хэлэх нь зүйтэй гэж үзлээ. Х. Цэвэлзэ гуай “Монголын нууц товчоо”-г Монголын ард түмний сонгодог бичлэгийн уламжлалыг өөртөө төгс төгөлдөр хадгалсан, монгол хэлний боловсронгуй хэлбэр болох туульсын хэллэгээр найруулан бичсэн сонгодог бүтээл гэж үзжээ. Үүнтэй хэн хүнгүй санал нийлэх буй заа. Тэрбээр “Монголын нууц товчоо” нь “Бодит баримт хийгээд болсон үйл явдлыг уран яруу зураглан бичдэг байсныг гэрчлэх бодит үлгэр жишээ мөн”¹ гэж үзсэн байна. Үүнийгээ үндэс болгож “Монголын нууц товчоо”-ны зарим зүйлээс иш татаж орчин үеийн сэтгүүл зүйн бичлэгийн арга хэлбэрүүдтэй харьцуулан жишиж өөрийн санал бодлоо хэлжээ.

“Монголын нууц товчоо” бол найман зууны тэртээд бүтээгдсэн алдарт хөлгөн их судар. Тэр үед орчин үеийн сэтгүүл зүй, нийтлэлийн талаарх үндсэн ойлголт үүсч бий болоогүй, тэр тусмаа бидний өнөөдрийн баримталж буй мэргэжлийн бичлэгийн төрөл, зүйлүүд төлөвшин бүрэлдэх нь алс хэтийн ирээдүйн үйл хэрэг байсан болохоор “Монголын нууц товчоо”-ны бичвэрийг өнөөдрийн сэтгүүл зүйн шалгуураар хэмжиж, үнэлж цэгнэж үзэх нь ихээхэн бэрхшээлтэй, зарим тохиолдолд боломж багатайг юуны өмнө тэмдэглэе. Хэдий тийм боловч аман болоод бичгийн утга зохиолын өнө эртний буурал түүхтэй эсгий туургатан монголчуудын хувьд XII зууны сүүлч, XIII зууны эхэн үеийн эзэнт Монгол гүрний үүсэл төлөвшил, хөгжил цэцэглэлийн он жилүүд нь ард түмэн, улс орон дамжсан мэдээллийн их үерийг өөрийн эрхгүй давалгаа-луулж, аман болоод бичгийн уран зохиолын цаашдын хөгжилд шууд нөлөөлөөд зогссонгүй, нийгмийн тавц-

наа болж буй түүхэн чухал тэмдэглэлт үйл явдлуудыг бичиж тэмдэглэж үлдээх зайлшгүй хэрэгцээ шаардлагыг аяндаа буй болгосон байна. Энэ цаг үе бол цоо шинэ “Их засаг” хууль эзэнт гүрэн даяар үйлчилж “Надтай зөвлөж, Шигихутугийн шийтгээд цагаан цаасан дээр хөх бэхээр бичиж дэвтэрлэснийг ургийн урагт хүртэл үүрд хэн ч бүү өөрчилтүгэй” хэмээн их эзэн Чингис хаан зарлиг болж байсан түүхэн цаг үе юм. Түүний хамгийн тод илэрхийлэл нь “Монголын нууц товчоо” өөрөө мөн.

Тийм болохоор XII зууны сүүлч, XIII зууны эхэн үеийг Монголын түүхэн дэх нийтлэл бичиг дурсгал, утга зохиолын мандал цэцэглэлийн алтан үе байсан гэж зүй ёсоор үзэх бүрэн үндэслэлтэй. Харамсалтай нь тэр цаг үед бүтээж туурвисан судар бичиг бүгд хадгалагдаж үлдсэнгүй, олонх нь үрэгдэж алга болсонд хамаг учир байгаа юм. Тухайн цаг үе, нийгмийн амьдралын талаарх хамгийн өргөн дэлгэр мэдээллийг өгч буй бүтээл нь “Монголын нууц товчоо”. Х. Цэвэлзэ гуай “Монголын нууц товчоо”-г сэтгүүл зүйн бүтээлийг бичдэг үндсэн аргуудаар бичсэн байна. Зонхилох хоёр арга хэлбэр байдаг. Түүний нэг нь хүүрнэн бичих буюу тоочих, нөгөө нь тодорхойлон бичих буюу зураглан дүрслэх арга юм. Түүнээс гадна ярилцах, егөөдөн ёгтлох, шаардлагатай гэж үзвэл шүлэглэн бичих тохиолдол бий...

“Монголын нууц товчоо”-г түүх, уран зохиолын дурсгал мөн болох талаас нь судалсан нь тоймгүй их байх боловч харин түүний бичлэгийн загварыг сэтгүүл зүйн нийтлэлд холбогдох талаас нь дорвитой дагнан судалсан судалгаа шинжилгээний ном судар элбэггүй байна. “Монголын нууц товчоо”-ны бичлэгийн арга хэлбэр нь сэтгүүл зүйн бичлэгийн ур ухаанд хэрхэн холбогдох

талаар өнөө хэр нэг мөр ойлголт төлөвшөөгүй шахам байж магадгүй... Хэрэв Монголын орчин үеийн сэтгүүл зүйд "Монголын нууц товчоо"-г найруулан бичсэн урлал зүйн үнэ цэнтэй уламжлалыг авч хэвшүүлэх тухайд хэлүүштэй зүйл байгаа нь үнэн бол өнөөгийн үеийнхэн л хэлж, цаашдын шинжилгээ судалгаанд бүдэг боловч зөрөг гаргах хэрэгтэй гэж бодно"² гэжээ.

"Монголын нууц товчоо"-г нийтлэлийн дурсгалт бичиг мөн болох, түүний бичвэрт сэтгүүл зүйн бичлэгийн аргууд, тэдгээрийн элементүүд байгаа эсэхийг дорвитойгоор гүнзгийрүүлэн судалсан нь үнэндээ бараг үгүй юм. Хуруу дарам цөөхөн өгүүлэл, ганц нэг номоос хэрхгүй байгаа уг сэдвийг дэлгэрүүлэн авч үзэх зайлшгүй шаардлагатай байгаа болно. Үүнийг хөндөж эрдмийн цол зэрэг горилсон, хамгаалсан дорвитой бүтээл туурвисан хүн өнөө хэр алга.

"Монголын нууц товчоо" судлаач эрдэмтэн Ш. Гаадамбын тоолж гаргаснаар "Монголын нууц товчоо"-нд уран дүрслэлийн аргаар бичсэн 29 хэсэг байгаа аж. Тэр 29 хэсэгт "Монголын нууц товчоо"-ны 97 зүйлийг хамааруулж болохоор байгааг Х. Цэвлээ гуай тэмдэглэжээ. Үндсэн 12 бүлэг, 282 зүйлтэй "Монголын нууц товчоо"-ны 30 хувийг нь үргэлжилсэн үгээр дүрслэх хэлбэрээр, үлдэх 70 хувийг нь хүүрнэн өгүүлэх аргаар тоочиж бичсэн байна.

Тэдгээрийн дотор мөнөөх 1500 мөр шүлэглэсэн бичлэгийг 147 газарт шигтгэн багтаасан байна. Бүгд 282 зүйлийн тал хувьд нь шүлэглэсэн бичлэг оруулсан байгаа юм. Миний ажигласнаар бодит үйл явдлыг шүлэглэн бичсэнээр түүний баримтлаг мөн чанар сулрахгүйгээр үл барам харин ч уншууртай мэргэн цэцэн болж тэдгээр шүлэг нь тухайлсан баримт сэлт хийгээд үйл явдлыг нь

лавшруулан илэрхийлэхэд хадаас шигтгээ, хачир чимэг болсон байна. Сайхан шүлэглэж чаддаг сэтгүүлчид хааяа уран яруу мөр бадаг оруулж байхад болохгүй гэх газаргүй гэж "Монголын нууц товчоо" өөрөө хэлээд байх мэт санагддаг бөлгөө"³ гэж тэрээр өөрийн санаа бодлыг илэрхийлжээ.

"Монголын нууц товчоо"-ны 30 хувийг үргэлжилсэн үгээр дүрслэн үзүүлж, үлдсэн 70 хувийг хүүрнэн өгүүлэх аргаар бичсэнийг Х. Цэвлээ тоолж тогтоожээ. Дүрслэн үзүүлэх ба хүүрнэн тоочих аргын харьцаа ойролцоогоор ийм байдалтай байгааг бидний тооцоо ч бас давхар баталж байгаа болно. 1500 мөр шүлэглэсэн хэсгийг 147 газарт шигтгэж өгснийг тэрбээр тэмдэглээд энэ нь "Монголын нууц товчоо"-г хадаас шигтгээ, хачир чимэг болгож улам мэргэн цэцэн болгож байна гэжээ. Энэ бол бодит үнэлгээ юм. Уншигчдыг хүндэтгэх үүднээс мэргэжлийн нэг хэллэгийг товч тайлбарлая. Сэтгүүл зүйн практикт бусдад үлгэр жишээ болохуйц сайн болсон бичлэгийг хадаас материал гэж нэрлэдэг юм. Өөрөөр хэлбэл үлгэр жишээ болохуйц эталон хэсэг гэж ойлгож болно. Хадаас шигтгээ гэсний учир энэ.

"Монголын нууц товчоо"-г амт шимт оруулж байгаа зүйл бол яах ч аргагүй уран яруу хэллэг, урт богино шүлгүүд мөн. Эдгээр шүлэг нь үйл явдлын баримтлаг чанарыг сулруулах биш харин ч улам уншууртай болгож байна гэж Х. Цэвлээ гуай гярхай ажиглаж, өнөө үеийн сэтгүүлчид үүнийг гүйцэд ашиглаж баймаар байна. "Монголын нууц товчоо"-ны бичвэрийн хэлбэр загвар ингэж бидэнд хэлж сануулаад байна гэжээ. Ер нь Х. Цэвлээ гуайн номын эл бүлэг бүхэлдээ ухаарал бясалгалын өнгө аястай, өнөө үеийн сэтгүүлчдийн анхаарлыг "Монголын

нууц товчоо"-ны бичвэрийн үлгэр загварт хандуулахыг зорьсон байдалтай ажээ. "Монголын нууц товчоо"-ны бичвэрээс үлгэр загвар авах зүйл бидний үеийнхэнд багагүй бий. Зарим зүйлийг шүлэглэж бичихэд ч болохгүй гэх газаргүй. Монгол Улсын төрийн соёрхолт яруу найрагч, МУСГЗ Долгорын Нямаа, МУСГЗ, Д. Нацагдоржийн шагналт зохиолч сэтгүүлч Дан. Нямаа нарын нийтлэлүүдэд ийм хэллэг, хэсгүүд цөөнгүй тааралддаг.

"Монголын нууц товчоо"-г эртний монгол хэлээс тухайн цагийн монгол хэл рүү хөрвүүлсэн нь Автономит Монгол Улсын үед хамаарах Цэнд гүнгийн орчуулга гэдгийг өмнө нь дурдсан. Тэрбээр "Монголын нууц товчоо"-ны шүлэглэсэн хэсгүүдийг хүүрнэн өгүүлэх аргаар хөрвүүлжээ. Үүнд нь академич Цэндийн Дамдинсүрэн шүүмжлэлтэй хандаж сүүлд холбогдох хэсгүүдийг шүлгээр хөрвүүлэн буулгасан байдаг. "Орчуулагч миний бие, монгол ардын аман зохиолоор шүлэг бичиж оролддог тул Нууц товчоог орчуулах ба ялангуяа түүний шүлгийг орчуулахад үнэн зүрхнээс сэтгэл хөдөлж, чухам тохиромжтой сайхан үүрэг гэж оролдож гүйцэтгэв"⁴ гэж Ц. Дамдинсүрэн гуай өмнөх үгэндээ тэмдэглэсэн нь бий. "Монголын нууц товчоо" бол бодит түүхэн үнэн үйл явдлуудыг хүүрнэн өгүүлэх хийгээд дүрслэн үзүүлэх, тухайлбал шүлэглэн буулгах бичвэрийг хослуулан туурвисан сонгодог бүтээл болно.

Х. Цэвлээ гуай "Монголын нууц товчоо"-нд Мэдээ маягийн бичлэг, Сурвалжлага маягийн бичлэг, Хөрөг маягийн бичлэг, Тэмдэглэл маягийн бичлэг, Өөрийн яриа буюу өгүүлэл маягийн бичлэг, Сурвалжилсан тэмдэглэл хэлбэрээр бичигдсэн зүйлс байна гэж үзээд өөрийнхөө жишээ

баримт, нотолгоогоор задлаж тайлбарлажээ. Мэдээ маягийн бичлэгт "Монголын нууц товчоо"-ны 59, 202, 265 дугаар зүйлүүдийг жишээлж авсан байна. (Х. Цэвлээ нь 2004 оны Д. Цэрэнсодном нарын "Монголын нууц товчоо"-ны хөрвүүлгээр авчээ. Эл орчуулга нь Ц. Дамдинсүрэнгийн хөрвүүлгээс зарим талаар зөрдгийг анхаарна уу. Т. Б.)

"Энд хэрэв XII, XIII зууны үед Монгол оронд тогтмол сонин бичиг гардаг байсан бол олон сонин мэдээ гарах байсан гэж үзэж болох байна.

"Есүхэй баатар Татаарын Тэмүүжин үгэ, Хори бухаа тэргүүтэн татаар иргэдийг дагуулж ирэх үед, жирэмсэн байсан Өгэлүн үжин Ононы Дэлүүн болдогт бүхүйд, чухам тэнд Чингис хаан төрөхүй. Чингис төрөхдөө баруун гартаа шагайн чинээ нөж атган төржээ. Татаарын Тэмүүжин үгээг авч ирэхэд төрөв хэмээн Тэмүүжин нэр өгсөн учир ийм" гэсэн мэдээ нийтлэгдэх байсан байх. Үүнийг задрүүлж харья. Хэн, хэзээ, хаана, юуг, яав гэсэн асуултанд хариулж бичдэг нь мэдээний дотоод дүрэм. Хэн? гэхээр Бөртэ үжин, хаана? гэхээр Дэлүүн болдогт, юуг? гэхээр Чингисийг, яав? гэхээр төржээ гэсэн хариулт өгсөн байна. Харин хэзээ? гэдгийг Есүхэй баатар Татаарын иргэнийг дагуулж ирэх үед хэмээн хариулжээ. Тэр үе нь 1162 он гэдэг байх. Энэ мэдээний дотор нэг оруулга оруулах шаардлага гарсан байна. Оруулга нь утга санааг шинэ баримтаар сэлбэж өгөх үүрэгтэй байдаг. Тухайлбал "Чингис төрөхдөө баруун гартаа шагайн чинээ нөж атган төржээ" гэсэн оруулга хийжээ. Эцэст нь тодруулга оруулсан байна. Тодруулга нь тайлбарлах чиг үүрэгтэй бичлэг байдаг. Энд Татаарын Тэмүүжин үгээг авч ирэхэд төрөв хэмээн Тэмүүжин нэр

өгсөн учир ийм" гэж тодруулан тайлбарлажээ. Манай мянганы аугаа их хүн хорвоод мэндэлсэн тухай мэдээг ийнхүү 47 үгтэй бэсрэгхэн бичлэгээр төгс хариу өгч чадсан нь "Монголын нууц товчоо"-ны уран бичлэгийн гайхамшигт баримт мөн⁵ гэжээ.

Өөрөөр хэлбэл "Монголын нууц товчоо"-ны 59 дүгээр зүйлийг 47 үгээс бүрдсэн бэсрэг мэдээ мөн гэж үзээд сэтгүүл зүйн бичлэгийн товч мэдээнд тавьдаг үндсэн гол шалгуураар шалгаж тэнцүүлсэн байна. Миний хувьд үүнтэй санал нийлж байгаа. 59 дүгээр зүйлд ямар нэгэн уран дүрслэл, уянгын халил бүхий адилтгал зүйрлэл, дүрслэл шүлэглэл зэрэг нэмэлт зүйл алга. Өзлүн эх Ононы Дэлүүн болдогт төрсөн. Энэ нь Есүхэй

баатар Татаарын Тэмүүжин үгэ, Хори бухаа тэргүүтэн татаар иргэдийг дагуулж ирэх үед тохиосон үйл явдал. Татаарын Тэмүүжин үгээг барьж авчрахад төрсөн тул түүнд Тэмүжин хэмээх нэрийг өгсөн. Төрөхдөө баруун гартаа шагайн чинээ нөж атган төрсөн гэсэн мэдээллийг уншигчдад өгч байна. Шагайн чинээ нөж атгаж төрсөн хэмээх тодотголыг л домгийн шинжтэй гэхгүй юм бол бусад нь бүгд үнэн бодитой, болж өнгөрсөн зүйлийг л шуудхан тоочин өгүүлж мэдээлжээ. Тэгэхдээ домог ч гэсэн мөн ялгаагүй үнэн бодит зүйлийг өгүүлэн үлдээдэг билээ.

Ийм мэдээ "Монголын нууц товчоо"-нд нэг биш байна гээд Х. Цэвлээ гуай "Монголын нууц товчоо"-ны 202 дугаар зүйлийг мөн иш татжээ. "Төдий эсгий

туургат улсыг шулуутгаж (нэгтгэж) барс жил (1206) Ононы тэргүүнээ хурж, есөн хөлт цагаан туг байгуулаад, Чингис хаанд хан цол тэнд өгөв"⁶. Мөнөөхөн бидний дэлхийн чихийг дэлдийлгэсэн гарамгай үйл явдал хэмээн нэрлэдэг Монголын нэгдсэн төр улс байгуулсан тухай мэдээг ердөө л хуруун чинээ мэдээнд багтаасан байна. Тоолоод үзэхэд ердөө хориодхон үгтэй байгаа

«

"Монголын нууц товчоо"-г амт шимт оруулж байгаа зүйл бол яах ч аргагүй уран яруу хэллэг, урт богино шүлгүүд мөн. Эдгээр шүлэг нь үйл явдлын баримтлаг чанарыг сулруулах биш харин ч улам уншууртай болгож байна гэж Х. Цэвлээ гуай гярхай ажиглажээ

»

"Улсыг шулуутгаж" гэжээ. Нэгтгэж гэх нь хурааж цуглуулахыг хэлдэг бол "Улсыг шулуутгаж" гэдэг нь чиг шулуун болгох үндсэн утгаараа Монгол Улс нэг мөрийн явдалтай бат цул улс байх боллоо гэсэн санааг илэрхийлэхэд илүү тохиромжтой байсан байж болох мэт. Ямар боловч "шулуутган" гэдэг нь олон хувилбартай үгнээс сонгож авсан шилмэл үг гэдэгт эргэлзэхгүй байна. Онон мөрний дэнжид чуулж гэхийг зүгээр л "хурж" гэсэн байна. Төр улсаа байгуулсан гэхийг "Есөн хөлт цагаан тугаа байгуулсан гэжээ"⁷ хэмээжээ.

Товч тодорхой мэдээ мөн гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Х. Цэвлээ гуай түүнийг хуруун чинээ гэж тодорхойлжээ. Маш бага зайд их мэдээллийг багтааж чаджээ. Ашигтай, идэвхтэй.

шинэлэг мэдээлэл мөн. Харин Ц. Дамдинсүрэн гуайн хөрвүүлэг арай өөр байгааг тэмдэглэе. Түүнд "Тэгээд эсгий туургатан улс энх шударга болж, барс жил (1206) Онон мөрний эхэнд хуралдаж, есөн хөлт цагаан тугаа мандуулаад Тэмүжинд Чингис хаан (Далай хаан) цолыг өргөв"⁸ гэсэн байна. Х. Цэвлээ гуайн олзуурхан шүүрч авсан "шулуутгаж", "хурж" гэсэн үг Ц. Дамдинсүрэн гуайн хөрвүүлэгт алга. XII-XIII зууны үеийн эртний монгол хэл дээрээ яг юу гэж тэмдэглэж үлдээсэн хийгээд түүнийг нь хэн хэрхэн яаж хөрвүүлснээс энэ мэт ялгаа гардаг ажээ. Ц. Дамдинсүрэн гуай Тэмүжинд Чингис хаан (Далай хаан) цолыг өргөв" гэсэн байхад Д. Цэрэнсодном нар "Хан цол тэнд өгөв", Ц. Дамдинсүрэн гуай "Есөн хөлт цагаан тугаа мандуулаад" гэсэн байхад Д. Цэрэнсодном нар "Есөн хөлт цагаан туг байгуулаад" хэмээн хөрвүүлж буулгасан байх жишээтэй. Тухайн цаг үед энд тэндгүй байсан олон бага хан нараас Тэмүжинг ялгаруулж харагдуулахын тулд Чингис хаан буюу Далай хаан гэсэн цолыг өргөмжилсөн гэж үзэх эрдэмтэд нэг биш байдаг. Энэ мэтээр хэлж ярих зүйл цөөнгүй байвч энэ нь бидний судалгааны үндсэн гол зорилго биш юм.

"Дараагийн мэдээ нь: "Нохой жилийн (1226) намар Чингис хаан Тангуд иргэнд мориллов. Хатадаас Есүхэй хатныг авч одов. Зуур замд өвөл Арбухын олон хуланг авлахад, Чингис хаан Зост борыг унаж явсан бүлгээ. Олон хулан дайрч ирэхэд, Зост бор үргэж, Чингис хаан мориноос унахад, бие нь маш ихээр өвдөж, Цоорхад буув. Тэр шөнө хоноод маргааш нь Есүхэй хатан өгүүллүүн: "Хөвүүд ноёд хэлэлцэгтүн. Хаан шөнө бие нь халуурч хонов" хэмээв"⁹ гэжээ. Энэ бол хэлбэрийн хувьд багцалсан мэдээ юм.

Нийтдээ 59 үгнээс бүрдсэн уг мэдээнд хоорондоо холбоо бүхий таван мэдээ багтсан байна. Манайхны одоогийн ойлголтоор бол үүнийг дуулиант мэдээ гэж болно. Эл багцын гол өгүүлэгдэхүүн нь "Зост бор үргэж, Чингис хаан мориноос унахад, бие нь маш ихээр өвдөж, Цоорхад буув" гэсэн хэсэг юм. Дэлхийн бараг тэн хагаст ноёрхлоо тогтоосон их хаан мориноос унаж чилээрхэнэ гэдэг яавч энгийн хэрэг биш¹⁰ хэмээн Х. Цэвлээ гуай бичжээ.

Шинж төрх, агуулга хэлбэрийн хувьд энэ нь дуулиант мэдээ лавтайяа мөн. Манайхан сенсац мэдээ гэж хуйлардаг. Чингис хаан Тангуд улсыг дагуулахаар дайлаар мордсон, хатадаас Есүхэйг авч явсан, зам зуурт Арбух гэдэг газар олон хуланг авласан, энэ авд Чингис хаан Зост борыг унаж явсан, олон хулан дайрч ирэхэд Зост бор үргэж, Чингис хаан мориноос унасан, бие нь чилээрхэж маш ихээр өвдсөний учир Цоорхад үдлэн буусан, шөнө нь ихэд халуурч хоносныг өглөө нь Есүхэй хатан хөвгүүд ноёдод мэдээлсэн гэжээ. Хэд хэдэн үйл явдлын агуулгыг товчлон базаж нэгтгэсэн байна. Агуулга, хэлбэрээрээ мэдээ мэдээллийн ангилалд багтана.

Энэ мэт чухал чухал үйл явдлын талаарх мэдээллийг багтаасан зүйл "Монголын нууц товчоо"-нд арвин байна. Х. Цэвлээ гуай тэдгээрээс зөвхөн гуравхныг жишээлжээ. Нэмж ганц хоёроор баяжуулья. Жишээ нь "Монголын нууц товчоо"-ны 98 дугаар зүйлд гарч байгаа "Хэрлэн мөрний эх Бүрги эрэгт нутаглан байтал, нэгэн өглөө эрт үүр цайж байхад Өзлүн эхийн гэрт зарцлагдах Хуагчин эмгэн босч үгүүллүүн: "Эх, эх үтэр бос. Газар дэлбэрэх мэт чимээ гарч, морины

төвөргөөн сонсдоно. Аймшигт тайчууд айсуу биз. Эх даруй бос¹¹ гэж байгаа хэсэг, эсвэл "Өэлүн эх мэргидийн нутгаас олж авсан Хүчү нэрт хөвүүн ба тайчуудын Бэсүдийн нутгаас олж авсан Хөхөчү, Татаарын нутгаас олж авсан Шигихутуг, Жүрханий нутгаас олж авсан Борохул энэ дөрвөн хөвүүнийг гэр дотроо асарч байв"¹² гэсэн 138 дугаар зүйлд өгүүлж байгаа хэсгийн агуулга аль аль нь товч тодорхой мэдээлэл мөн болно. 98 дугаар зүйлд аймшигт тайчууд айсууг яаравчлан мэдээлж байхад 138 дугаар зүйлд дайн тулааны явцад мэргид, тайчууд, бэсүдийн болоод Татаар, Жүрханий нутгаас олж авсан Хүчү, Хөхөчү, Шигихутуг, Борохул дөрвийг Өэлүн эх гэртээ асарч тэжээж байгааг өгүүлжээ. Эдгээр нь хэзээ, хаана, юу болов гэсэн товч мэдээний сонгодог асуултад хангалттай хариулт өгч чадаж байна. Эхнийхийг авч үзье. Хэзээ? гэсэн асуултад өглөө эрт үүр цайж байхад гэж хариулж байгаа бол хаана энэ үйл явдал болов? гэсэн асуултад Хэрлэн мөрний эх Бүрги эрэгт нутаглаж байхад хэмээн хариулж байна. Юу болов? гэсэн асуултад газар дэлбэрэх мэт чимээ гарч, морины төвөргөөн сонсдоно. Аймшигт тайчууд айсуу биз. Эх даруй бос гэж хариулж байна. Дараагийн мэдээнд хэн? гэсэн асуултад Өэлүн эх, хаанаас? гэсэн асуултад Мэргидийн, Бэсүдийн, Татаарын, Жүрханий нутгаас олж авсан, хэн? гэсэн асуултад Хүчү, Хөхөчү, Шигихутуг, Борохул дөрвийг, юу болов? гэсэн асуултад асарч тэжээж байв гэж хариулжээ.

Энэ бүгдээс үзэхэд "Монголын нууц товчоо"-ны мэдээ маягийн бичвэрээр үнэхээр элбэг баян болох нь ойлгогдож байгаа юм. Эл хөлгөн их сударт мэдээ мэдээллийн зүйл сонгодог утгаараа ч

байна, мэдээ бичлэгийн элементүүд шингэсэн хэсэг ч тааралдаж байна.

"Сурвалжлага хэлбэрээр бичигдсэн хувилбартай дүйцүүлж болохоор найруулан бичсэн өгүүлэмжүүд "Монголын нууц товчоо"-нд нилээдгүй байгаа"¹³ гэж Хорлоогийн Цэвэлээ тэмдэглээд "Монголын нууц товчоо"-ны 61, 62, 63 дугаар зүйл¹⁴ иш татаж эл санаагаа нотолгоожуулаад "Хүүрнэн өгүүлэх аргаар тоочин бичдэг уламжлал бүр эртнийх юм байна"¹⁴ гэсэн дүгнэлт хийжээ. 61-63 дугаар зүйлд Есүхэй баатар Тэмүжинг 9 настай байхад Өэлүн эхийнх нь төрхөм олхуноудаас охин гуйхаар явж байгаад зам зуурт Дэй сэцэнтэй тааралдаж, тэд хэрэг зоригоо мэдэлцэн, Дэй сэцэн урьд шөнө зүүд зүүдэлснээ тайлж уншиж байгаа тухай өгүүлдэг билээ.

Сэтгүүл зүйн бичлэгт сурвалжлага хэмээх зүйл эрт дээр үеэс уламжлалтай бөгөөд өдөр тутам хэрэглэгддэг нийтлэг бичвэр юм. Сурвалжлага гэдэг үгнээс сурвалжлагч гэсэн нэр томъёо үүссэн нь үүнийг батална. "Сурвалжлага бол дэлхий дахины тогтмол хэвлэлд үлэмж дэлгэрсэн гол зүйлийн нэг мөн. Сурвалжлага гэдэг нь "уламжлах", "мэдээлэх" гэсэн утгатай латин гаралтай үг юм. Энэ утгаар нь сонин сэтгүүлд зориулж бичсэн мэдээллийн чанартай бүх материаллыг сурвалжлага гэнэ.

Сурвалжлага гэдэг нь сэтгүүлч өөрөө оролцсон үйл явдлынхаа тухай сэтгэл хөдөлгөөм бөгөөд ил шууд өгүүлдэг бичлэгийн шуурхай зүйл юм"¹⁵ гэж доктор Л. Норовсүрэн сэтгүүл зүйн бичлэгийн сурвалжлага хэмээх зүйлийг онолынх нь талаас тодорхойлжээ. Олон улс орны сэтгүүл зүйн эрдэмтэд ингэж үздэг бөгөөд нэг биш сурах бичиг, сэтгүүл зүйн тайлбар толь иймэрхүү байдлаар тайлбарлаж,

тодорхойлсон байгаа. Сурвалжлагыг уншсан уншигч тухайн үйл явдалд сэтгүүлч өөрөө оролцох явцад юуг олж үзсэн, ямар бодол сэтгэгдэл төрсөн, яг тэр хэмжээгээр адилхан түвшинд хүлээж авч чадаж, ойлгон мэдэрч байгаа бол тэр сурвалжлага мөн гэсэн ойлголт практикт түгээмэл байдаг юм. Энэ шаардлагын үүднээс авч үзэх юм бол зөвхөн 61-63 дугаар зүйлийг төдийгүй "Монголын нууц товчоо"-ны 54-56 дугаар зүйлд өгүүлж буй үйл явдлыг ч сурвалжлагын бичвэр, түүний элементүүдэд хамааруулж үзэж болохор байна. Үүнд:

54§ Тэр цагт Есүхэй баатар, шувуу агнан явах зуур олхуноуд аймгаас эм аваад буцаж яваа мэргидийн их чилэдү гэдэг хүнтэй уулзаж, түүний эмийг өнгийж үзвэл гуа үзэсгэлэнтэй хатан байна. Есүхэй баатар гэртээ давхиж ирээд Нэгүүн тайж, дүү Даридай отчигин хоёрыг дагуулан мордож, их Чилэдүүг гүйцэж очвол,

55§ Тэр айж хурдан ухаа морины гуяыг ташуурдаж, уулын бэлээр дутаав. Түүнийг гурвуулаа цувалдан хөөвөл тэр улам дутаасаар нэгэн хошууг тойрч эргэж тэргэндээ хүрч ирсэнд эм Өэлүн үжин (фүжин гэж хятадаар хатныг хэлнэ) үгүүлрүүн: "Тэр гурван хүний учрыг мэдэв үү чи? Тэдний царай сэжиглэмээр байна. Чиний аминд хор хүргэж болно. Амьд мэнд үлдвэл эхнэрийг олоход бэрхгүй. Мухлаг тутам охид бий. Тэрэг тутам хатад бий. (Миний мэт өнгөт эхнэр олдоно. А. То) Хэрэв намайг санавал дахин авсан гэргийг миний нэрээр нэрлэгтүн. Одоо амиа арчил. Миний үнэрийг үнсч яв" гээд өмссөн цамцаа тайлж өгөв. Их Чилэдү, тэр цамцыг морин дээрээс тонгойж авмагц харвал нөгөө гурав мөн хошууг тойрч нэхэн айсуу. Чилэдү хурдан ухаа морины

гуяыг ташуурдаж яаран Онон мөрөн өөд дутаав.

56§ Түүнийг гурвуулаа хойноос нь нэхэж, долоон даваа давтал хөөж орхиод Өэлүн үжинг авч, Есүхэй баатар жолоодон хөтөлж, ах Нэгүүн тайжи тэргүүлж, дүү Даридай отчигин хажууд дагаж (тэмээг гилж А. То) явна. Үүнд Өэлүн үжин үгүүлрүүн: "Миний эр Чилэдү,

Сэрүүн салхинд

Сэвлэг үсээ хийсгэж

Хээр хөдөө

Гэдсээ өлсгөж яахин зовох болов?

Одоо би, хоёр сэвлэг үсээ хойш урагш унжуулж яахан одно?" гээд Онон мөрнийг долгиотол, ой шугуйг ганхтал их дуугаар уйлахад Даридай отчигин хажуунаас үгүүлрүүн:

"Тэврэх хайрт эр чинь

Тэртээ давааг давав

Уйлан санах эр чинь

Ус олныг гэтлэв

Хайлж уйлавч

Харж чамайг үзэхгүй

Хайж эрэвч

Хаалга зам нь олдохгүй

[Гурван гол гэтэлгэв

Гурван гурви давуулав

Хайвал мөргүй

Харвал бараагүй

Хайлбал үл сонсдоно. Ч. ц] Дуугүй бай! гэж ятгав.

Өэлүн үжинг Есүхэй баатар тэгээд гэртээ авчирч гэргий болгов. Өэлүн үжинг Есүхэй баатрын авчирсан ёс ийм бүлгээ¹⁶ хэмээжээ.

Тухайн цаг үед болж өнгөрсөн үйл явдлыг бидний нүдэнд үзэгдэж, сэтгэлд хоногштол өгүүлэн хүүрнэжээ. Болж өнгөрсөн явдлыг цаг хугацааны дэс дарааллаар нэмж чимэлгүйгээр, илүү дутуу үгүй тоочин өгүүлж байна. "Монголын нууц товчоо"-г зохиогч өөрөө уг үйл явдалд оролцож, нүдээр

үзэж харсан адил энгүүн бөгөөд ойлгомжтойгоор хүүрнэсэн аж. Үйл явдлаа хүч оруулах үүднээс шүлэглэж зураглан баатруудаа тодотгожээ. Ингэж сурвалжлан тодотгож өгүүлсэн хэсгүүд "Монголын нууц товчоо"-нд нэг бус удаа тааралдаж байгаа нь сэтгүүл зүйн бичлэгийн сурвалжлагад хамааруулж болох, уг бичлэгийн арга зүй, элементүүдийг өөртөө агуулсан бичвэрийн хэлбэр уг зохиол дотор бодитой байгааг гэрчилж байгаа юм.

Х Цэвлээ гуай "Монголын нууц товчоо"-нд Хөрөг маягийн бичлэг байна гэж үзээд түүнийхээ жишээ болгож уг зохиолын 54,55 дугаар зүйлийг хөрөг найрууллын шинж төрхтэй гэж тодорхойлжээ. Миний санахад эдгээр хэсгийг хөрөг найрууллын шинжтэй гэхээсээ илүүтэйгээр сурвалжилсан тэмдэглэлийн хэлбэрээр зохиогдсон, үйл явдлын зурагласан сурвалжлага гэж үзэж байна. Найруулал, түүний дотор хөрөг найрууллын сэтгүүл зүйн бичлэгийн бусад төрөл, зүйлээс ялгарах гол онцлог нь дүр бүтээх явдал юм. Тийм ч учраас судлаачид найрууллыг уран зохиолын бага, харин сэтгүүл зүйн дээд (төрөл) зүйл гэж нэрлэдэг билээ. "Монголын нууц товчоо"-ны 54, 55 дугаар зүйлд Есүхэй баатар, Их Чилэдү, Өзлүн үжинтэй холбоотой зүйлийг өгүүлж байгаа боловч тэдний хэн нэгний дүрийг товойлгон гаргасан гэж хэлэхэд учир дутагдалтай юм. Харин 55 дугаар зүйл, ялангуяа 56 дугаар зүйлд Өзлүн үжиний дотоод сэтгэлийг нээж үзүүлэхийг "Монголын нууц товчоо"-г зохиогч эрмэлзсэнийг, тэр нь уншуур-тай яруу сайхан болсныг цохон тэмдэглэх ёстой. Хэдий тийм боловч энэ нь хөрөг найрууллын түвшинд гэхээсээ илүүтэйгээр зураглаж сурвалжилсан тэмдэглэлийн байдалтай болсон мэт санагдаж байгаа

болно. Сурвалжилсан тэмдэглэлд тасар, саг зураглал, таашаал авахуйц дүр дүрслэл олонтаа тааралддаг билээ.

Ийм зураглалтай хэсэг "Монголын нууц товчоо"-нд нэг биш бий. Жишээ нь "Монголын нууц товчоо"-ны 184 дүгээр зүйлд алтан тэрэм босгоод хуримлаж суугаа Ван хан Тоорилоос Хасарт илгээсэн элч Итүргэний тухай гардаг. Тэнд "Тэрхүү Итүргэн, Халиудар Чахурхан хоёрын хамт уг болзсон Аргал хохи гэдэг газар хүрч ирээд их бараа (олон хүн, мал)-г үзэж Итүргэн элч (сэжиглэж) буцан дутаав. Халиударийн морь хурдан тул даруй нэхэж гүйцэвч барьж чадахгүй, өмнө хойно нь орж явахад Чахурханы морь удаан тул хойноос арай гэж сум хүрэлцэх газарт ирж, Итүргэний алтан эмээлт хар морины гуяны угийг хойш унатал харважээ"¹⁷ гэсэн хоёр өгүүлбэр бий. Энд мөн л болсон үйл явдлыг зураглан өгүүлжээ. Хурдан морьтой Халиудар, удаан морьтой Чахурхан хоёр Ван ханы эргэж зугатсан элч Итүргэнийг зууралдан хөөцөлдсөн, нум сум хүрэх газар ирмэгц Чахурхан харваж унагасан тухай зураглан хүүрнэж үзүүлжээ.

Х. Цэвлээ гуай "Монголын нууц товчоо"-ны 197 дугаар зүйлд гарч байгаа хэсгийг тэмдэглэл маягийн бичлэг гэж үзжээ. Д. Цэрэнсодном нарын 2004 онд хийсэн "Монголын нууц товчоо"-ны орчуулгаар жишээлжээ. 225 үгтэй, 12 өгүүлбэрээс бүрдсэн, бусдад сургажтай, сэтгэлд зурагдал бичсэн гэж тодотгожээ. Тэнд 8 мөр шүлэг бий. Харин Ц. Дамдинсүрэн гуайн (1976 оны хэвлэлээр жишээлэв) хөрвүүлэгт 270 үгнээс бүрдсэн 9 өгүүлбэртэй, 14 мөр шүлэгтэй болой. Аль аль орчуулалт авах ба гээх зүйл бий санагддаг.

Увас Мэргидийн тэргүүлэгч Дайр-Үсүн өөрийн охин Хуланг Чингис хаанд үзүүлэхээр авчрах замд Бааридай

Наяа ноёнтон тааралдах агаад хэрэг зоригоо хэлбэл үймээн самуунтай ийм цагт ингэж хамаагүй явж болохгүй, зам зуурт цэргүүд охинтой чинь самуурч болзошгүй, намайг гурав хоног хүлээ, хамт очъё гэж Наяа ноён хэлжээ. Ийм зүйл болсныг сонсоод Чингис хаан хилэлнэж Наяа ноёноос ял асуухыг завдахад Хулан түүнийг өмөөрч, үнэн худлыг түүнээс биш надаас, эцэг эхээс төрүүлсэн мариа биеэс минь асуувал ямар гэж хэлж буй тухай, их хаантан зөвшөөрөн соёрхож, Наяа ноён шударга нэгэн болохыг мэдэж буй тухай 197 дугаар зүйлд өгүүлдэг билээ.

"Бичлэгийн арга барилын хувьд хүүрнэн тоочих аргыг хэрэглэсэн байна. Наяа ноёнтон учирсан тухай хэсэгт Наяагийн нэгдүгээр биеийн хүүрнэлээр тодруулга хийж, Чингис хаантай уулзсаны дараах хэсэгт Хулан хатны нэгдүгээр биеийн хүүрнэлээр оруулбал тоочилт хийжээ. Мөн энэ хэсэгт "Эдүгээ Наяагаас асууснаас, хаан соёрхвоос, тэнгэрийн заяагаар эцэг эхийн төрүүлсэн мариа биеэс минь асууваас ямар?" хэмээсэн нь нийтлэлийн хэллэгээр бол яах аргагүй хадаас чанартай өгүүлэгдэхүүн болжээ. Шударга үнэний төлөө тэмцэл ямар их адармаатай, түүнийг андуурч эндүүрэхгүй танихад бодит үнэн баримт ямар их ач холбогдолтойг ойлгуулж байна. Хэрэв үнэн бодит баримт байгаагүй бол Чингис хаан өөрийн хамгийн үнэнч анд Наяа ноёныг хэлмэгдүүлэн хороох аюул гарцаагүй тулгарах байсан байна... Ийм болзошгүй нөхцөлд цаад эх үүсвэрээр нь нотолж чадах баримтанд тулгуурлахгүй бол тодорхой хүнийг, тэр байтугай бүхэл бүтэн улс орон, ард түмнийг ч хилсдүүлэн нөхөгдөшгүй хохироож болохыг сануулснаараа "Монголын нууц товчоо"-ны 197 дугаар хэсэг танин мэдэ-

хүйн асар их ач тустай юм"¹⁸ гэж сэтгүүлч Х. Цэвлээ тэмдэглэжээ.

Хашир туршлагатай сэтгүүлчийн эл гярхай ажиглалт уран өгүүлэмж ба баримтын уялдаа холбоог тодотгон, түүнд уншигчдын анхаарлыг хандуулжээ. Энэ нь сэтгүүл зүйн тэмдэглэл, тэмдэглэлийн элементийг шингээж өгсөн сурвалжилсан тэмдэглэл зэрэг бичлэгт их тод ажиглагддаг содон шинж юм. Нийтлэл, уран сайхны бичлэгийн төрөлд хамаарагддаг тэмдэглэл бол нийтлэлийн нэн эртний зүйлийн нэг бөгөөд дотроо мэдээлсэн тэмдэглэл, шүүмжилсэн тэмдэглэл, дурсамж тэмдэглэл гэх зэргээр ялгарна. Доктор Л. Норовсүрэн "Манай өнөөгийн тогтмол хэвлэлийн тэмдэглэлийг мэдээлэл, нийтлэлийн аль алины нь зорилтыг агуулсан уран дүрслэл, задлан шинжилгээний аргыг хослуулан хэрэглэдэг нийтлэл-уран сайхны бичлэгийн зүйл гэж үзвэл зохино"¹⁹ гэжээ. Гадаад дотоодын олон эрдэмтэд, түүний дотор Оросын сэтгүүл зүйн олонх судлаачид ч тэмдэглэлийг ийнхүү тодорхойлсон байдаг.

Тэмдэглэл хэмээх нэн эртний үүсэлтэй бичлэгийн эл зүйлд тавьдаг үндсэн гол шаардлагын дагуу "Монголын нууц товчоо"-ны бичвэрийг судалж шинжиж үзэхэд түүний олон зүйл, хэсэг чухамхүү тэмдэглэлийн өнгө аястай байгаа нь эрхгүй мэдрэгдэнэ. Сэтгүүл зүйн бичлэгийн бусад төрөл зүйлүүдээс "Монголын нууц товчоо"-нд хамгийн элбэгээр тааралдаж байгаа нь тэмдэглэл, тэмдэглэлийн хэлбэртэй уран нийтлэл юм. Тийм учраас "Монголын нууц товчоо"-г манай уран нийтлэлийн охь дээж болсон дурсгалт бичиг мөн гэж үзэх бүрэн үндэслэлтэй. "Монголын нууц товчоо"-ны 251 дүгээр зүйлд "Чингис хаан, Дүн гуан боомтыг хүрвэл хятадын

цэргүүд уулыг бүрхэж, хөндийг бялхаж байна²⁰, 31 дүгээр зүйлд "Баруун хойноос салхи салхилбал түүний харцгаар бариулсан нугас, галууны өд сөд нь цас мэт бутарч хийсч ирнэ"²¹, 260 дугаар зүйлд "Чингис хаан тайтгарч, Зүчи, Цагадай, Өгэдэй гурван хөвүүнийг уулзуулж донгодож, өвгөдийн үгийг өв болгож, хуучин үгийг хууль болгож, байсан газар нь тогтож ядтал, магнайн хөлсийг арчиж ядтал зэмлэж буруушааж байхад..."²², 272 дугаар зүйлд "Туулай жил (1231) Өгэдэй хаан, хятад иргэнд морилж, Зэвийг манлай болгож илгээв. Тэгээд Хятадын цэргийг хиартал хядаж, Цавчаалын даваагаар давж зүг зүг олон хотыг хааж байлдах цэргүүдийг явуулав"²³ гэх зэргээр гарч байгаа нь үүнийг гэрчилнэ. Үүн дээр "Монголын нууц товчоо"-нд байгаа 1500 мөр уран яруу шүлэглэлийг бас нэмж дурдах хэрэгтэй. Дүр дүрслэлийг шүлгээр зурж үзүүлсэн нь нэн олон агаад эдгээр нь уг бүтээлийн баримтлаг чанарыг огтхон ч бууруулсангүй, харин ч уран яруу уншууртай болгожээ гэдэгтэй санал нийлэх нь зүйтэй болов уу.

Х Цэвлээ гуай "Монголын нууц товчоо"-ны 281 дүгээр зүйлээр буюу Өгэдэй хаан эзэн Чингис хааны их сууринд суугаад үйлдсэн дөрвөн сайн үйлс ба дөрвөн буруу зүйлсийг өгүүлж буйг өөрийн яриа буюу өгүүлэл, мөн тэрчлэн Зэлмэ эзэн хааныхаа бөглөрсөн цусыг шимэн асгаж амь насыг нь аварч буй 145 дугаар зүйлээр баримт татаж сурвалжилсан тэмдэглэлийн хэлбэртэй бичлэг мөн байна гэж үзжээ. Өөрийн яриа буюу Өгэдэй хааны өчлийн хэсгийг Х. Цэвлээ гуай өгүүлэл гэж үзсэнийг доктор Л. Норовсүрэн асуудал дэвшүүлсэн өгүүлэлтэй төстэй гэж тодотгосон байдаг. Чингис хаан, түүний үнэнч

нөхөр Зэлмэ хоёрын нэгэн байлдааны явцад шархдаж бэртсэн шөнийн үнэн бодит үйл явдлыг уран яруугаар тэмдэглэж үлдээснийг нь сурвалжилсан тэмдэглэл биш гэж эсэргүүцэх боломж хэр баргийн хүнд олдохгүй болов уу гэж бодож байна. "Мянгаад жилийн тэртээх гайхамшигтай уран бичлэгийн нэг их сурвалж энэ байна. Энд Чингис ба түүний баатарлаг нөхдийн гүн зузаан дайчин нөхөрлөлийг нэгэн удаагийн азгүй тохиолдлын үнэн баримтыг сурвалжилсан тэмдэглэл мэтээр тэр үед тэдний эв нэгдэл ямар байсныг яг тэр чигээр нь буулгаж үлдээсэн байна... Энэ бол 1201 оны орчим болсон явдлыг бичсэн сэтгүүл зүйн хэллэгээр бол тэмдэглэлийн төрөл зүйлд багтах уран бүтээл мөн байх"²⁴ гэжээ. "Монголын нууц товчоо"-ны бичлэгт зөвхөн сэтгүүл зүйн мэдээ төдийгүй сурвалжлага, сурвалжилсан тэмдэглэл, улмаар өгүүлэл, тэмдэглэл, уран нийтлэлийн бичлэгийн арга хэлбэр, тэдгээрт шингээстэй байдаг элементүүд, өвөрмөц шинж тэмдгүүд элбэг баян байна. Дуртгал тэмдэглэл, ярилцлага гэж үзэж болох хэсэг ч тааралдаж байна. Жишээ нь "Монголын нууц товчоо"-ны 177 дугаар зүйл үүнийг батална.

Урьдны яриа хэлэлцээг улалзтал хэлж, Тоорил хааны өнгөрсөн, баларсан үйлдэл нэг бүрийг босгон ирж ядарч зүдэрч, зовж туйлдаж явахад нь Есүхэй хан эцэг нь, улмаар өөрөө хэрхэн ач тус хүргэснээ тоочин хэлж

Өлсөх өдөр чинь

Өршөөн тэжээсэн би

Өнчрөх сард чинь

Өмөглөж тэтгэсэн би хэмээн нэхэн сануулаад одоо хан эцэг минь, би ямар хэрэгт буруудаж, чиний хилэнг хүргэв гэж асуужээ. Энэ нь үнэн хэрэг дээрээ "За гэвэл ёгүй Монголын андгай

хаачсан бэ?" гэж ял тулгасантай яг адилхан сонсогдож байна. Бичлэгийн агуулга нь эргэж дурсах, эргэцүүлэн бясалгах, сануулан хэлэх, саар үйлдлээс урьдчилан сэргийлэх зэргийг бүгдийг зэрэгцүүлэн хослуулжээ. Би цөөн боловч олноос дутахгүй, муу боловч сайнаас дордохгүй, хоёр аралтай тэрэгний нэгэн арал хугарвал, үхэр түүнийг чирч чадахгүй. Тэр мэт нэгэн арал чинь би биш билүү гэх зэргээр хурц цэцэн цэлмэг үгээр нэн урнаар өгүүлж, хэлүүлсэн эзнийх нь сэтгэлийн хөдлөл, уур хилэн, уцаар дургүйцэл хийгээд эргэлзэл гайхширлыг зэрэг зэрэг дүрслэн үзүүлж чадсан байх ажээ. Бичвэрийн арга хэлбэрийн хувьд дуртгал тэмдэглэлийн хэлбэртэй болжээ гэлтэй. Энэ тухай буюу 177 дугаар зүйлийг ард бүрэн эхээр нь дэлгэрүүлж ярина.

“Монголын нууц товчоо”-ны 70 ба 71 дүгээр зүйлд сэтгүүл зүйн ярилцлага хэмээх зүйлд хамааруулж ойлгож болох хэсэг бий. 70 дугаар зүйлд "Тэр хавар Амбагай хааны хатан Орбай Сохатай хоёр ихсийн газар (Өвгөдийн хүүр оршуулах газар) тайлгын идээ өргөхөд Өэлүн үжин хождож очсон тул тайлгын идээний хувиараас хоцрогдов. Орбай Сохатай хоёрт Өэлүн үжин үгүүлрүүн: "Есүхэй баатрыг үхэв гэж, хөвгүүдийг минь балчир гэж, ихсийн тайлгын хишгийн архи сархдаас яахан хождуулав та? Нүд үзсээр үл өгөх, нүүхдээ үл хэлэх болов та" гэжээ. 71 дүгээр зүйлд "Тэр үгэнд Орбай Сохатай хоёр хатан хариу үгүүлрүүн:

"Урьж чамд өгөхгүй

Учирбал чи идэх ёстой

Хүргэж чамд өгөх ёсгүй

Хүртвэл чи идэх ёстой

Амбагай хаан үхээд, Өэлүнд ийнхүү хэлэгдэх болов"²⁵ гэсэн байдаг. Энэ

бол Өэлүн эх ба Орбай Сохатай нарын хооронд болсон яриа. Цэвэр ярилцлагын хэлбэртэй. Ихсийн тайлгад хожимдож очсон Өэлүн эх тэдэнд гомдож үнэнийг хэлэхэд харах, хандах эзэнгүй хаягдсан түүнд хатуурхан хэлж байгаа хатдын хариу үгс. Залгуулаад 72 дугаар зүйлд маргааш нь тэднийг нутаг орхин тайчуудын Таргудай-Хирилтуг, Тодойн-Гиртэ нар Онон мөрөн рүү нүүж, Чирха өвгөн нүүдлийг болиулах гэж ятгахад хариуд нь Тодойн-Гиртэ

"Цээлийн ус ширгэв

Цэгээн чулуу хагарав" гээд өвгөний зоо нурууг жадлан хөөж буй тухай өгүүлдэг билээ.

Х. Цэвлээ гуайн өгүүлсэн дээрх бол эргэцүүлэлтэй нарийвчлан танилцахын сацуу "Монголын нууц товчоо"-ны зохиогчийн бичлэгийн арга хэлбэрийг анхааралтайгаар ажиг шинжилж үзэхэд сэтгүүл зүйн бичлэгийн мэдээ, сурвалжлага, сурвалжилсан тэмдэглэл, өгүүлэл, тэмдэглэл, дуртгал тэмдэглэл, ярилцлага зэрэгт бүрэн хамааруулж болох мэдээллийн болоод уран сайхны нийтлэлийн өнгө аяс бүхий бичвэр цөөнгүй байгаа нь баталгаатай аж. Үүнээс үзэхэд Монголд аман болоод бичгийн нийтлэлийн уламжлал эрт дээр үеэс үүсэл гаралтай нь улам бүр тодорхой болж байгаа бөгөөд харин сэтгүүл зүйн шинжлэх ухааны үүднээс бичлэгийн төрөл, зүйлд хуваан яс ангилж хайрцаглаад хэвшүүлэн тогтоож хэрэгжүүлж мөрдүүлсэн нь нилээд хожуу буюу сонин, сэтгүүл Монголд сонгодог утгаараа гарч эхэлсэн сүүлийн зуун жилд хамаарах ажээ.

Энэ нь ч зүй ёсны хэрэг агаад уламжлалаа хадгалан хөгжиж улам бүр боловсронгуй болгосоор байгаа сэтгүүл зүйн бичлэгүүдийн төрөл зүйл, түүний арга барил, зохиомжийг үүнээс

өөрөөр ойлгож төсөөлөх боломжгүй болно.

“Монголын шилдэг нийтлэл” цуврал 99 ботийн Ерөнхий редактор, Хорлоогийн Цэвэлзэгийн уран бүтээлийн 59 дэх ботийг ариутган шүүж, хянан тохиолдуулагч “Өөрийгөө шинжээч бус сонгооч гэж нэрлэсэн Х. Цэвэлзэ гуайн “Монголын нууц товчоо” бүтээлд хийсэн ажиглалт онцгой гойд сонирхолтой, цоо шинэ санаагаар бялхан цалгилж байгааг зориуд олзуурхан тэмдэглэж хэлэх нь зүйтэй болов уу. “Монголын нууц товчоо” дахь мэдээ маягийн бичлэг, хөрөг маягийн бичлэг, тэмдэглэл маягийн бичлэг, өөрийн яриа буюу өгүүлэл, сурвалжилсан тэмдэглэлийн хэлбэрийг тус тус нухацтай авч үзсэн байна. “Монголын нууц товчоо” бол Монголын утга зохиолын хосгүй нандин дурсгалт бичиг мөнхийг Цэндийн Дамдинсүрэнгээс эхлээд нэг биш сод эрдэмтэд баталж нотолсон нь бий. Харин сэтгүүл зүйн бүтээл мөн болох талаас нь яагаад ч юм эдүгээг хүртэл хэн ч хэлж дуугарсангүй яваа аж. Х. Цэвэлзэ гуай түүнийг авьяаслаг, туршлагатай сэтгүүлчийн зөн совингоор хамгаас түрүүнд олж харсан байна. Энэ бол нээлт мөн. “Монголын нууц товчоо” зөвхөн утга зохиолын төдийгүй сэтгүүл зүйн хосгүй нандин бүтээл мөнхийг цаашид гүнзгийрүүлэн судалбаас зохилтой санагдана²⁶ гэж тэмдэглэжээ.

Уг нь энэ санаа Х. Цэвэлзэ гуайд нилээд эрт төрсөн бололтой. 1999 онд “Зууны мэдээ” сонинд “Түүхийн хурдан хүлэг эцэж цуцах учиргүй” гэсэн эргэцүүлэл нийтлэл хэвлүүлжээ. Түүндээ анх хэлсэн байна. “Монголын нууц товчоо”-нд хэдэн арваар тоологдох газар ус, хүний нэр гардаг л даа. Тэр дунд зохиомол нэр байхгүй гэж баттай хэлж болох юм.

Тэгвэл «Нууц товчоо» маань сэтгүүл зүйн бүтээл юм биш үү. Монголд төдийгүй дэлхийд нэрлэгдэх сэтгүүл зүйн сонгодог анхны том бүтээл ч юм уу хэн мэдлээ. Манайхан хэл, түүх уран зохиол талаас нь чамлалтгүй судалж дэлхийн дэвжээнд дуу хоолойгоо хүргэсэн нь магтууштай, бахдууштай хэрэг. Харин сэтгүүл зүйн талаас хэр судалж, үгээ хэлснийг би хувьдаа мэдэхгүй юм. Сэтгүүл зүйн бүтээл мөн үү, биш үү гэдгийг нь гадаад, дотоодын шинжээчдийн хэсэг ажиллуулж байгаад ч болов тогтоолгох юмсан гэж бодох юм. Хэрэв түүнийг **сэтгүүл зүйн сонгодог бүтээл мөн** байна гэвэл тогтоочихдогсон бол Монгол Улсын хөгжилд ач тустай олон ажил хийх бололцоо нээгдэнэ. Юуны өмнө 2000 оны 7-р сард болох “Монголын нууц товчоо”-ны 760 жилийн ой угаж сэтгүүл зүйн сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг хийх, энэ бүтээлд тэмдэглэгдсэн газар орноор аялал зохиох, Нууц товчооны нэрэмжит олон улсын сэтгүүлчдийн шагналын сан байгуулах гэх мэт олон төрлийн ажлыг зохион байгуулж болно. Ялангуяа Монгол орон сэтгүүл зүйн мянгаад жилийн уламжлалтай гэж дэлхийд зарлан олон улсын сэтгүүлчдийн байгууллага болон ЮНЕСКО-д бүртгүүлбэл ихээхэн амттай юм болно” хэмээн бичсэн байгаа юм. Сүүлд дэлгэрүүлж баяжуулаад 2010 онд “Миний сэтгүүл зүй II” номондоо, улмаар шилдэг нийтлэлийн 59 дүгээр ботидоо оруулжээ.

Энэ сэдвээр доктор профессор Л. Норовсүрэн 2004 онд бас өөрийн санааг дэвшүүлэн тавьсан байдаг. Тэрбээр МУИС-ийн “Сэтгүүл зүй” эрдэм шинжилгээний бичигт өгүүлэл бичжээ. Уг өгүүлэлдээ “Монголын нууц товчоо”-нд сэтгүүл зүйн бичлэгүүд байна гэж

үзсэн байна. Тухайлбал “Монголын нууц товчоо” нь одоогоос 700-800 жилийн тэртээх монгол үндэстний эрхэлдэг аж ахуй, амьдралын хэв маягийн тухай арвин мэдээллийг агуулснаараа нийтлэлийн шинжтэй юм. Ах нар нь урагт эс тооцож, хувь эс өгсөнд гомдсон Бодончар Онон мөрний Балжийн аралд хүрч өвсөн эмбүүл барьж “морины хялгасаар урхи хийж... бор харцагийг барин авчирч” тэжээгээд “Хавар болж нугас ирэх цагт харцага сойж тавиад галуу нугас олныг алж” (Н. Т. 25, 26 дугаар зүйл) гэдсээ тэжээж байдаг. Түүнчлэн

Гоо төрсөн Өзлүн эх

Гох дэгээ барин явж

Гол завьг өгсөж уруудаж

Хутагтан хөвгүүдээ тэжээж өсгөв (Н. Т. 74 дүгээр зүйл) гэх мэтээр бичсэн нь үнэн хэрэгтээ аж ахуйн чанартай мэдээлэл, бусдад санаа төрүүлсэн нийтлэлийн шинжтэй юм. Тэр зөвхөн гогод мангир төдийгүй олирс мойл, сөдөн хичгэнэ, затгас төмсийг хүртэл хүнсэндээ хэрэглэж байсныг энэ шүлэглэлд мэдээлсэн байна. Түүгээр зогсохгүй

Сайхан Хилго мөрөнд

Сахал өвс их гэнэ

Сахал өвс түүгээр

Сал хийж болдог гэнэ (Н. Т. 105 дугаар зүйл) гэж байгаа нь хэдийгээр шүлгийн хэлбэртэй боловч агуулгаараа амьдралд ашигтай мэдээ байна. Сахал өвс байгаа газрыг мэдэж, түүгээр сал хийж болдгийг сонссон, тийм хэрэгцээтэй хүн үйл ажиллагаагаа шууд эхлэх бололцоотой болж байгаагаараа энэ мэдээ ихээхэн үр ашигтай юм. Өнөөгийн ойлголтоор энэ нь шинэ санаачилга, туршлага дэлгэрүүлэхэд чиглэсэн мэдээ болно. Мэдээлэл бол эрин цагийнхаа тусгал, ирээдүй хойчдоо түүх болж үлддэг зүйл юм. Мэдээжээр

“Монголын нууц товчоо”-ны зохиогч найман зуун жилийн дараа аж төрөх бидэнд л үзүүлэхийг урьдал болгож ийнхүү алдарт дурсгалыг бичээгүй, харин цаг үеэ тусгаж, өөрийн үеийнхэнд зориулсан бичсэн байх²⁷ гэжээ.

Сэтгүүл зүй бол эрэн үеэ үнэн бодитойгоор бичиж тэмдэглэж үлдээдгээрээ уран зохиолоос ялгардаг. Утга зохиолд санаанаасаа зохиомжилж болдог бол сэтгүүл зүйд тэгж болохгүй. Зөвхөн үнэнийг өгүүлнэ, баримтад тулгуурлана.

“Монголын нууц товчоо”-нд XII зууны сүүлч, XIII зууны эхэн үеийн эзэнт Монгол гүрний нийгмийн амьдралыг толь мэт тодхон тусгаж үлдээжээ. Үүгээрээ “Монголын нууц товчоо” уран зохиолоос илүү үнэ цэнтэй бөгөөд нийтлэлийн бүтээл мөн гэж нэрлүүлэх нэг үндэслэлийг буй болгож байгаа билээ. Тийм учраас бид доктор профессор Л. Норовсүрэнгийн дүгнэлттэй санал нийлж байгаагаа тэмдэглэхийн хамт энэ чиглэлээр хийгдсэн судалгаа шинжилгээний ажил хэтэрхий хомс цөөн байгааг эрхбиш ухамсарлан ойлгож өөрсдийн өчүүхэн судалгаагаараа бага боловч лавшруулан гүнзгийрүүлэхийг эрмэлзсэн болно.

“Монголын нууц товчоо”-нд “Бие тэргүүнтэй, дээл захтай нь сайн” (33-р зүйл), “Нуган хүүхэд нутгаа эзэмшинэ, охин хүүхэд өнгө шилэгдэнэ” (65-р зүйл), “Цээлийн ус ширгэв, цэгээн чулуу хагарав” (72-р зүйл), “Сүүдрээс өөр нөхөргүй, сүүлнээс өөр ташуургүй” (76-р зүйл), “Хурганы үс гуужив, төлөгний үс төлжив” (79-р зүйл), “Өдөр үзэх нүд, шөнө сонсох чих” (138-р зүйл), “Дэлэм үг, алд хэл” (169-р зүйл), “Хэлээ татаж, амаа барих” (169-р зүйл), “Морин унаатан, модон нөмөртөн” (174-р зүйл), “Зээгийн зүсээр, охины өнгөөр” (176-р зүйл), “Саруул ухаанаас

өөр сайн нөхөр байдаггүй, мунхаг хилэнгээс илүү муу дайсан байдаггүй” (235-р зүйл), “Хандгайг харваад, оготныг онох” (255-р зүйл), “Өвсөнд ороовч үхэр тоож идэхгүй, өөхөнд хучивч нохой тоож идэхгүй” (255-р зүйл) гэх мэт зүйр цэцэн хийгээд сургаал үгс хэдэн зуугаараа тоологдоно”²⁸ гэдгийг Л. Норовсүрэн өгүүлэлдээ онцлог тэмдэглээд “Монголын нууц товчоо”-нд бас өнөөгийн нийтлэлч нар заавал өвлөн авч хэрэглүүштэй нэг сайхан уламжлал байна. Энэ нь юмс үзэгдлийг гайхалтай товч болоод яруу илэрхийлэх чадвар юм. Жишээ нь “Мартсаныг саануулж, унтсаныг сэрүүлж” (255-р зүйл), “Өвгөдийн үгийг өв болгож, хуучин үгийг хууль болгож” (260-р зүйл), “Бургилсан зүрхийг дарах нөхөр болж, буцалсан усыг сэвэх шанага болж” (277-р зүйл), “Халуун сэтгэлээр ятгаж, хамраасаа утаа гартал хэлэх” (242-р зүйл), “Өшил өчиж, хясал хясах” (214-р зүйл) гэх мэт чухам нэг шигтгээ болсон оновчтой үг хэллэгийг өнөөгийн сэтгүүлчид донжийг нь тааруулан ашиглаж байгууштай юм”²⁹ гэжээ.

Энэ бол “Монголын нууц товчоо”-нд ардын аман зохиол, зүйр цэцэн үг зэрэг яруу хэл хэллэгийг гайхалтай чадмаг ашиглаж чадсаны илэрхийлэл юм. Өнөө үеийн сэтгүүлчдэд өвлөж авууштай зүйлс “Монголын нууц товчоо”-нд энэ мэтээр маш их бий гэдэгтэй бүгд санал нийлэх буй заа.

Судлаач Л. Норовсүрэн “Чингис хаан Уйгурын Идүүдэд Агалтун бэхи

охиноо өгөх үед “Хатагтай хүнд гурван эр бий. Анхны эр нь алтан төр. Түүний дараах эр нь ариун нэр. Түүний дараах эр нь авсан эр мөн билээ. Алтан төрийг хатуужиж дагавал ариун нэр бэлэн болно. Ариун нэрийг бэхэлбэл авсан эр ангид үл одно” (Н. Т. 238-р зүйл) гэж хэлсэн нь төр ёсны гүн утга бүхий сургаал нийтлэл байна. Бас Тэмүжин Ван хаан, Жамуха анд нартай юуны

учир эцэг үр, анд нөхдийн барилдлагатай болж, хэрхэн нөхөрлөж явснаа дурссан хэсэг, хаан болсны дараа хүлэг баатар, иргэлт нөхдийнхөө ач тус, байгуулсан гавьяаг нэхэн хэлэлцэж байгаа зэрэг нь дурсамж тэмдэглэлийн маягтай болсон байдаг”³⁰ гээд “Монго-

лын нууц товчоо”-ны 279 дүгээр зүйлд гардаг Өгэдэй хааны өгүүлж буй “Чингис хаан эцгийн зовж байгуулсан улсыг бүү зовооё. Хөлий нь хөсөр, гары нь газар тавиулж жаргуулья. Хаан эцгийн бэлэн суурийг эзлээд иргэнийг үл зовоохыг эрхэм болгоно. Шөл шүүс болгож харьяат зуун хониноос нижээд шүлгэн жил тутам авч байна. Ядуучуудын тусламж болгож өгтүгэй... Бас улс иргэний нутаг усыг хувааж өгье. Нутгийг хувааж, сонгож нутаглахад мянгат бүрээс нутагчныг ялгаж гаргавал болно. Бас цөл говь нутагт гөрөөснөөс өөр амьтангүй байна.

Ард иргэн уужим суухыг хүснэ. Чинай, Уйгуртай хоёр тэргүүтэй нутагчныг явуулж, цөл говьд худаг малтуулж хашуулья. Бас элч нарыг одоогийн байдлаар явуулахад элч нар

удаан явах ба ард олонд зовлон чирэгдэл үлэмж байна. Одоо бид байнга журам болгож, зүг зүгийн мянгатаас замчин улаачин гаргаж, суурь суурьт өртөө тавьж, элч нарыг ард олны дундуур хамаагүй уургын улаа унаж, хэсүүчлэн давхихгүй, гагцхүү өртөө замаар явах болгоё” (Н. Т. 279-р зүйл) гэж байгаа нь аль ч шинжээрээ өнөөгийн сонинд гардаг асуудал дэвшүүлсэн өгүүллээс ялгарах юмгүй байна”³¹ гэжээ.

Судлаач Л. Норовсүрэн “Монголын нууц товчоо”-нд сургаал нийтлэл, дурсамж тэмдэглэл, асуудал дэвшүүлсэн өгүүллэйн шинж төрхийг агуулсан хэсгүүд байна гэж үзсэнийг эндээс харж болно. Энэ нь Х. Цэвлээгийн санал бодолтой тун ойролцоо байна. Нэр дурдсан бичвэрүүдийн талаар бид өөрсдийн санал бодлоо мөн хэлэх бөгөөд ерөнхийдөө судлаачийн дэвшүүлсэн саналыг дэмжиж буйгаа илэрхийлье.

Л. Норовсүрэн ийнхүү “Монголын нууц товчоо”-нд гарч буй хэд хэдэн зүйлээр жишээлж өгүүлээд “Монголын нууц товчоо”-г нийтлэлийн дурсгал гэж үзэхдээ хоёр зүйлийг үндэс болгож байна. Энэ нь нэгдүгээрт: Уг зохиол бүхэлдээ буюу ерөнхий агуулгаараа тухайн цаг үеийнхээ улс төрийн үйл явдал, ард түмний ахуй амьдрал, ёс заншлыг нийгмийн өргөн дэлгэц дээр тавьж үзүүлсэн, хоёрдугаарт Зохиолыг бичиж туурвихдаа нийтлэлийн элементийг өргөн ашигласан явдал болно”³² гэжээ. Тэрбээр цааш нь өгүүлэхдээ “Монголын нууц товчоо”-г нийтлэлд холбогдуулж үзэх хоёр дахь шинжийг дараах гурван чиглэлээр тодруулж үзүүштэй байна. Үүнд: **нэгдүгээрт**, “Монголын нууц товчоо” нь эртний монголчуудын мэдээллийн харилцааны арга хэлбэрийн талаар үнэтэй

мэдээллийг өгч байгаа, **хоёрдугаарт**, XII, XIII зууны үеийн бичгийн зохиолд орчин үеийн нийтлэлийн зарим шинж агуулагдаж байсныг энэ зохиолоос мэдэж болох, **гуравдугаарт**, Уг зохиолоос тухайн үеийн монгол үндэстний эрхэлдэг аж ахуй, эдэлж хэрэглэдэг зүйлийн талаарх мэдээллийг авч болдог зэрэг юм”³³ гэжээ.

Энэ бүхнийгээ нэгтгэн дүгнэж үзээд доктор профессор Л. Норовсүрэн “Монголын нууц товчоо” нь:

- Өгүүлэл, тэмдэглэл, тайлан, мэдээ зэрэг орчин цагийн нийтлэлийн шинжтэй зүйлийг арвин ихээр агуулж байгаа;

- Цаг үеийнхээ үйл явдлыг шуурхай тусгах үлгэр жишээг үзүүлж байгаа;

- Товч тодорхой бөгөөд яруу сайхан илэрхийлэх аргад сургаж байгаа;

- Ардын аман зохиолын өвийг бичгийн зохиолд идэвхлүүлэн ашиглахын бэлэн загварыг үзүүлж байгаа. зэргээрээ нийтлэлийн үнэт дурсгал болох юм”³⁴ гэсэн үндсэн дүгнэлт хийсэн байна.

“Монголын нууц товчоо”-н дахь үнэн бодит баримтуудын мөрөөр мөшгөж, уг зохиолыг хуучин монгол хэлээс орчин цагийн монгол хэл рүү хөрвүүлсэн үндсэн гурав, дөрвөн хувилбарыг харьцуулан судалж, эл зохиолын гол баатар “Мянганы суут хүн” эзэн Чингис хаанаас хүн төрөлхтөний хөгжилд гүйцэтгэсэн үүрэг, түүхэнд түүний эзлэх байр суурийг дэлхийн тавиад улс орны төрийн тэргүүнүүд хэрхэн үнэлж дүгнэснийг “Их Монгол Улс” номын үндсэн баримтаар жишээлж нотолж батлан харуулахыг өмнөх бүлгүүдэд оролдсон билээ.

2004 онд Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг ёслон тэмдэглэсэн нь Монголын эзэнт гүрэн, эзэн Чингис хааны үйл амьдрал, үнэн

бодит байдлыг тал бүрээс нь нээн үзүүлсэн бүтээл туурвилыг олшруулахад хүчтэй түлхэц үзүүлжээ. "Монголын нууц товчоо"-ны хамтын шинэ орчуулга 2004 онд хийгдэж, "Их Монгол Улс" ном хэвлэгдэж гарсан байна. "Монголын нууц товчоо"-нд гардаг 383 бодит хүний тухай өгүүлсэн Ш. Цэен-Ойдов, Ц. Сарангэрэл нарын "Монголын нууц товчоон 383 хүний түүхэн товчис" хэмээх ном ч мөн онд хэвлэгдэн гарчээ. Судлаач Ө. Бавуу, Х. Шагдар, Д. Пүрэвдорж нарын бүтээлүүд хэвлэгджээ.

Эдгээрээс зарим судлаач, тухайлбал доктор профессор Л. Норовсүрэн, Т. Баасансүрэн, Х. Цэвлээ, Ш. Цэен-Ойдов, Ц. Сарангэрэл нар "Монголын нууц товчоо"-г үнэн бодит баримтын товчоон, нийтлэлийн бичлэгийн арга хэлбэрийг гойд чадмаг ашиглаж туурвисан хосгүй нандин бүтээл гэж үзсэн байна. Доктор Л. Норовсүрэн "Монголын нууц товчоо"-нд асуудал дэвшүүлсэн өгүүлэл, тэмдэглэл, тайлан, мэдээ гэсэн сэтгүүл зүйн бичлэгийн хэлбэрүүд байна гэж үзсэн бол МУСГЗ Х. Цэвлээ удиртгал мэдээлэл, мэдээ, сурвалжлага, тэмдэглэл, өгүүлэл, сурвалжилсан тэмдэглэлийн хэлбэрүүд уг зохиолд ажиглагдаж байгааг тэмдэглэж жишээ баримтаар батлах оролдлого хийжээ. Нэр дурдсан сэтгүүл зүйн судлаачид, уг сэдвийг хөндөж ном зохиол өгүүлэл туурвисан дээрх зохиогчдын бүтээлүүдээс үзэхэд тэд "Монголын нууц товчоо" нь нийтлэлийн гайхамшигт бүтээл мөн гэдэгтэй үндсэндээ санал нэгдэж байгаа аж.

Хэрэв "Монголын нууц товчоо" нийтлэлийн хосгүй нандин бүтээл үнэхээр мөн юм бол түүнийг сэтгүүл зүйн шинжлэх ухааны үүднээс, өөрөөр хэлбэл бичлэгийнх нь үндсэн арга хэлбэрээс эрж хайж баталгаажуулж болох учиртай. Бидний өмнөө тавьсан

судалгааны нэг үндсэн гол зорилго бол энэ. "Монголын нууц товчоо"-нд нийтлэлийн үндсэн гол шинжийг илэрхийлсэн ямар ямар зүйлс байна, тэр нь хэрхэн яаж тухайлбал сэтгүүл зүйн бичлэгийн ямар хэлбэрээр илрэн гарч байна, "Монголын нууц товчоо"-нд ер нь нийтлэлийн өнгө аяс байна уу, үгүй юу? Байвал тэдгээрийг сэтгүүл зүйн бичлэгийн ямар төрөл, зүйлд хамааруулж болох вэ гэдгийг нарийвчлан судалж үзэх нь Монголын сэтгүүл зүйн онол, практикт онцгой ач холбогдолтой юм. Урьдах яриагаа улам лавшруулж үргэлжлүүлэе.

"Монголын нууц товчоо"-ны 33 дугаар зүйлд "Бодончар, Буха хатаги ахын хойноос даган хатирч үгүүлрүүн: "Ахаа, ахаа, бие тэргүүтэй, дээл захтай сайн" гэвэл, ах нь тэр үгийг хайхарсангүй", мөн зохиолын 34 дүгээр зүйлд "Бодончар мөн үгийг хоёрдугаар удаа үгүүлбэл, ах нь хариу хэлсэнгүй. Мөн үгийг гуравдугаар удаа хэлэхэд ах нь үгүүлрүүн: "Чи энэ үгийг юун дахин дахин үгүүлнэ?", "Монголын нууц товчоо"-ны 35 дугаар зүйлд "Бодончар үгүүлрүүн: "Тугаарын (саяын) Түнхэлэг горхиноо бүхий иргэнд эзэнгүй, их бага сайн муу, толгой шийр цөм нэгэн адил чацуу байна. Ийм хялбар иргэн тул тэднийг бид эзэлж авъя", "Монголын нууц товчоо"-ны 36 дугаар зүйлд "Ах нь үгүүлрүүн: "За тийм бол гэртээ хүрч, ах дүү нартай зөвлөлдөж, тэд иргэнийг эзэлье гэж"³⁵ хэмээн гарч байна.

А лун-гуа эхийг үгүй болсны дараа ах дүү тавуулаа адуу малаа хувааж аваад дүү Бодончар мунхагийг ядуу гэж урагт үл тооцон хувь эс өгдөг. Урагт эс тооцогдсон Бодончар гол дайрт годон сүүлт орог шинхул морио унаад Онон мөрөнг зорьж Балжийн арал гэдэг газар хүрээд өвсөн эмбүүл гэр барьж

суугаад хар хур шувууг барьж идэх харцагыг хялгасаар урхидан барьж тэжээгээд галуу нугасыг олноор бариулан өлсөж өлбөрөх аюулаас мултран амь зуудаг билээ. Тэгж суухад нь нэгэн бүлэг иргэн Түнхэлэг горхин руу нүүж ирэн суурьшиж, Бодончар тэднийд өдөр бүр очиж цэгээ гуйж уугаад шөнө өвсөн эмбүүл гэрт эргэж очиж хонодог тухай "Монголын нууц товчоо"-нд өгүүлдэг. Бодончар ийнхүү амь зуухын төлөө тэмцэж, тэр явцдаа өөрөө өсч хөгжиж байна. Харцага шувууг барьж авч тэжээхээс эхлээд өдөр бүр тэдгээр бүлэг иргэнд очиж цэгээ олж уух явцдаа орой дээрээ ахлах захилах удирдагч эзэнгүй тул олзолж авахад түвэггүй болохыг ойлгож ухаарчээ.

А жиглалт бол амьдралын туршлага хуримтлуулах, өсөж дэвжих үндсэн гол арга юм. Үүнийг амьдрал практикт сэтгүүл зүй нь өгүүлэл, тайлан зэрэг бичлэгээр илүүтэй илэрхийлэн гаргаж иржээ. Өгүүлэл бичлэгийн нэг гол онцлог, бусад бичлэгээс ялгарах давуу тал нь танин мэдэхүй бөгөөд хүмүүс амьдралыг ажиглаж таньж мэдэхийн хэрээр амьд бясалгалаар улам бүр цэнэглэгдэж урагшлай тэмүүлж, хөгжиж дэгжиж байдаг. Шинжлэлт тайлан бичлэгт гэхэд зохиогч тухайн үйл явдлын учир шалтгааныг олохыг хичээх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэхийг чухалчилдаг. Энэ бүхнийг бодолцон үзэх юм бол Бодончар мунхагийн ажиглалтын үр дүнд олж авсан мэдлэг мэдээллийн талаарх "Монголын нууц товчоо"-ны 33-36 дугаар зүйлүүдийн бичлэгт сэтгүүл зүйн өгүүлэл, шинжлэлт тайланд ажиглагддаг элементүүд байна гэж үзэх үндэслэл байна.

Ази, Европыг холбосон аугаа их эзэнт гүрнийг байгуулахад шуурхай мэдээлэл маш их хэрэгтэй байжээ.

Дайн байлдааны хувь заяанд цагаа олсон үнэн бодитой, шуурхай, тагнуулын мэдээлэл ус цас шиг чухал хэрэгцээтэй байсныг "Монголын нууц товчоо"-нд нэг биш удаа өгүүлсэн байна. "Монголын нууц товчоо"-ны 124 дүгээр зүйлд их эзэн Чингис хаан итгэлт сайн дайчин нөхөддөө тус тусын чиглэлээрх үүргийг хүлээлгэж эрхлэх ажлыг хуваарилахдаа "Архай Хасар, Тахар, Сүхэхай, Чаурхан, дөрвийг "Хо-лын холбогч, ойрын оторч" (Хол ойрыг сурвалжлах газарч) болтугай гэв"³⁶ хэмээн гардаг нь үүнийг гэрчилнэ.

"Монголын нууц товчоо"-ны 203 дугаар зүйлд эзэн Чингис хаан итгэлт сайн нөхөддөө өндөр дээд соёрхол хүртээж эзэнт төрийн өмнө байгуулсан их гавьяаг нь товойлгон тодотгож үнэлэхдээ Шигихутуг хандан "Мөнх тэнгэрийн ивээлээр улс гүрнийг тохинуулж байхад чи, үзэх нүд, сонсох чих болж яв"³⁷ хэмээн онцолдог. Мөн "Монголын нууц товчоо"-ны 210 дугаар зүйлд "Хунан, Хөхөчос, Дэгэй, Усун өвгөн энэ дөрвүүл, үзсэнээ нуухгүй, үнэн үгээ хэлж, мэдсэнээ мэлээхгүй, сонссон үгээ сонсгодог билээ"³⁸ хэмээн Чингис хаан хэлж байгаа төдийгүй улмаар 216 дугаар зүйлд "Чингис хаан, Усун өвгөнд үгүүлрүүн: "Усун, Хунан, Хөхөчос, Дэгэй энэ дөрвүүлээ, үзсэн сонссоноо үлдээж нуулгүй, үргэлж хэлдэг билээ. Монголын төр ёсонд бэхи ноёдыг өргөмжлөх заншил бий. Ахмад үеийн хүнээ бэхи болгодог заншилтай тул баарин ахын ураг, Усун өвгөнийг бэхи болгоё. Бэхи өргөмжлөгдөөд цагаан дээл өмсөж, цагаан морь унаж, дээд сууринд сууж, он сарыг олж сонгож байтугай"³⁹ гэж зарлиг болов хэмээн үнэн бодит мэдээллийн үнэ цэнийг өргөмжлөн соёрхол хүртээж байгаагаас ч давхар нотлогдож байна. Мэдээллийн ач

холбогдлыг Монголын төрт ёсны уламжлал, түүний батжил, бэхжилттэй холбож үзжээ.

"Монголын нууц товчоо"-ны 235 дугаар зүйлд эзэн Чингис хаан Харлагуудын Арслан хаан байлдалгүй дагаар орсныг ихэд сайшаан соёрхож Алха бэхи охиноо өгөхдөө түүнд хандаж

Харайхад минь хөл болж
Хазайхад минь түшиг болж
Халтирахад минь тах болж
Халамж тус хүргэхээ
Хайрт Алха минь мэдтүгэй
Эрхэм итгэл олон боловч
Энэ бие бүгдээс итгэлтэй
Хайрлах юм олон боловч

Халуун амийг хамгаас хайрлалтай гэж⁴⁰ итгэмжлэн хэлж байгаа нь цаанаа ихэд нарийн утга учиртай санагдана. Энэ нь нэг талаар охин Алхагаар найрамдалт харилцааг ургийн ёсоор баталгаажуулж бэхжүүлж байгаа бодит үнэн мөн боловчиг нөгөө талаар түүнд гүн их итгэл хүлээлгэж халамж тус хүргэхээ хайрт Алха минь мэдтүгэй гэж давхар захиж гэрээсэлж байна. Энэ бол эзэн төрдөө үнэнч байгаарай, итгэлтэй үнэн мэдээлэл өгч байгаарай гэсэнтэй агаар нэгэн гэлтэй.

Ийм санаа "Монголын нууц товчоо"-нд нэг биш удаа гардаг. "Монголын нууц товчоо"-ны 238 дугаар зүйлд Уйгурын Идүүд хан дагаар ороход Чингис хаан сайшаан Алалтун бэхи охиноо өгөхдөө "Хатагтай хүнд гурван эр бий. Анхны эр нь алтан төр. Түүний дараах эр нь ариун нэр. Түүний дараах эр нь авсан эр мөн билээ. Алтан төрийг хатуужиж дагавал ариун нэр бэлэн болно. Ариун нэрийг бэхлэлэл авсан эр ангид үл одно"⁴¹ гэж Чингис хаан сургадаг.

Алтан төрийг хамгаас эрхэмлэж, ариун нэрийг хатамжлан бэхжүүлж төр,

түмэн олондоо үнэнч явах тухай эдгээрт өгүүлж байна. Чингис хаанд итгэлт бие төлөөлөгч шиг үнэтэй зүйл байсангүй. Эрхэм итгэл олон боловч энэ нь улам ч тодорч байна. "Монголын нууц товчоо"-ны 138 дугаар зүйлд "Ээлүн эх Мэргидийн нутгаас олж авсан Хүчү нэрт хөвгүүн ба Тайчуудын бэсүдийн нутгаас олж авсан Хөхөчү, Татаарын нутгаас олж авсан Шиги-хутуг, Жүрханий нутгаас олж авсан Борохул энэ дөрвөн хөвүүнийг гэр дотроо асарч байв. Ээлүн эх хөвүүдээ үгүүлрүүн: "Эднийг өдөр үзэх нүд, шөнө сонсох чих болгоё гэв"⁴² хэмээн гарч байгаагаас үзэхэд ч мэдээлэл, үнэн бодит мэдээнд ямар их ач холбогдол өгч байсан нь эрхгүй мэдрэгдэнэ.

Эзэн Чингис хааны дайн байлдааны арга тактик, түүний төгс ялалтын учир холбогдол, уг сурвалжийг элчийн мэдээ мэдээлэлгүйгээр, өөрөөр хэлбэл тэдний зар хэл, өнөөгийн ойлголтоор бол тагнуулын мэдээлэлгүйгээр бүрэн гүйцэд ойлгох ямар ч боломжгүй юм. Үүнийг "Монголын нууц товчоо"-ны олон зүйлээс тодорхой харж болно. Жишээ нь уг зохиолын 132 дугаар зүйлд "Чингис хаан "Вангин чансан, Мэгүжин-сүүлт тэргүүтэн Татаартай байлдаж, Улз гэдэг газар өөд адуу малын хамт түрэн хөөж айсуу гэх мэдээг авав. Мэдээг аваад

133§ Чингис хаан үгүүлрүүн: "Хэдийнээс Татаар бол бидний эцэг өвгөдийг алсан өштөн иргэн билээ. Одоо энэ алалдаанд хавсралцаа" гээд Тоорил ханд элч зарж "Алтан хааны Вангин чансан, Мэгүжин-сүүлт тэргүүтэн Татаарыг Улз өөд түрж айсуу гэнэ. Эцэг өвгөдийг хорлосон өшөөт Татаартай байлдъя. Тоорил хан эцэг даруй иртүгэй" гэж явуулав. Энэ хэлийг

аваад, Тоорил хан үгүүлрүүн: "Хөвүүн (Чингис) минь зөв үг хэлж ирүүлжээ. Бид хавсран байлдъя" гээд гуравдугаар өдөр цэргээ цуглуулж мордоод Тоорил даруй Чингисийг угтан хүрч ирэв. Чингис хаан, Тоорил хан хоёр Сача бэхи тэргүүтэй жүрхин нарт хэлүүлсэн нь: "Энэ байлдаанд хавсарч, эртний эцэг өвгөдий минь хорлосон Татаартай байлдахаар хамт мордье" гэж элч явуулаад зургаан өдөр хүлээвч, тэд ирсэнгүй. Хүлээж ядаад Чингис хаан, Тоорил хан хоёр цэргээ авч Вангин чансантай хавсрахаар Улз өөд явж очвол, Улзын Хусуту Шитүэн, Нарату шитүэн гэдэг газар Татаарын Мэгүжин-сүүлт тэргүүтэн татаар нар хороо бэхлэлтийг барьжээ. Чингис хаан, Тоорил хан хоёр тэрхүү Мэгүжин-сүүлт нарыг бэхлэлтээс нь барьж, Мэгүжин-сүүлтийг тэнд нь алаад мөнгөн өлгий ба тана эрдэнийн чимэгт хөнжлий нь Чингис хаан олзлон авав"⁴³ хэмээн гардаг.

"Монголын нууц товчоо"-ны 132 ба 133 дугаар зүйлд гарч байгаа эдгээр үйл явдал нь тухайн тэр цаг үед элчийн мэдээ ямар их үнэ цэнтэй зүйл байсныг илтгэн өгүүлээд зогсохгүй бичлэгийн арга хэлбэр нь өөрөө хэзээ, хаана, юу болов, хэнээс хэнд юу гэж хэлүүлэв, хэлүүлсний дараагаар үйл явдал яаж өрнөв, ямар үр дүнд хүрэв гэдэгт тов тодорхой хариулт өгч буйгаараа ашигтай, идэвхтэй, шуурхай, товч тодорхой мэдээллийн шилдэг үлгэр дуурайл, хэв загвар болж байна. Энд ямар нэгэн уянгын халил, адилтгал зүйрлэл, зураглал дүрслэл, илүү дутуу тайлбар алга. Энэ бол нэр үл мэдэгдэгч зохиогч "Монголын нууц товчоо"-нд мэдээнд тавигддаг эдүгээгийн шаардлагыг тэр эрт цаг үед нэн чадмаг ашиглаж чадаж байсныг гэрчилнэ. "Монголын нууц товчоо"-нд гардаг Чингис хааны Ван Тоорил, анд

Жамуха, Нилха Сэнгүм нарт илгээсэн алдарт аман илгээлтүүд бол буруу явдлыг баримт түшин ухааруулж, зөв үйлдлийг нотолж итгүүлж үнэмшүүлсэн нэн өндөр үнэ цэнтэй ухааруулах, урьдын явдлыг эргэж сануулах мэдээллүүд болно. Эрдэмтэн мэргэд Монголд эрт дээр үеэс элч зарж алс газарт мэдээ занги дамжуулдаг байсан тухай тэмдэглэсэн нь цөөнгүй бий. Ялангуяа дайн самуунтай цаг үед элчийн мэдээг илүү найдвартай гэж үздэг байсантай энэ нь холбоотой юм. Ийнхүү элчээр мэдээ дамжуулахыг монголчууд "Дуу бариулах" гэдэг байсан бөгөөд "Монголын нууц товчоо"-ны нэг биш хэсэгт, жишээ нь 199 дүгээр зүйлд дуу бариулав хэмээн гарч байна. "Энэ нь мэдээ чимээ зөвхөн элчийн дуу хоолойгоор дамжих учрыг илтгэх бөгөөд хүргэх мэдээнийхээ агуулгыг гүн утга, яруу сонсголон бүхий шүлгийн хэлбэрт оруулаад элчид ягштал цээжлүүлсний дараа илгээдэг байжээ"⁴⁴ хэмээн доктор Л. Норовсүрэн тэмдэглэжээ. Үүнийг доорх жишээ батална.

"Монголын нууц товчоо"-ны 177 дугаар зүйлд: "Чингис хаан, хонгирадыг оруулаад тэндээс нүүж Түнхэлэг горхины зүүн этгээдэд хүрч буугаад Архай Хасар, Сүхэхэй Жэун хоёрыг элч болгон томилж (Ван ханд) хэлүүлсэн нь: "Бид Түнхэлэг горхины зүүн этгээдэд буув. Энд өвс сайн ургажээ. Агт морьд минь тамиржиж байна. Хан эцэгт минь ингэж үгүүлтүгэй: Хан эцэг минь, юунд хилэгнэж, намайг юунд айлгав? Муу хөвүүд, муу бэрүүд биднийг амар унтуулахгүй юунд айлгаж байна,

Сандайлж суух орыг минь
Салбагнуулан түлхэж
Савсан гарах утаагийг минь
Сацуулан хийсгэж
Санамсаргүй муу хөвүүнээ юунд

Сандруулан хөнөөв чи?

Хан эцэг минь чи

Хажуугийн ховч хүний

Халтай муу үгэнд

Хатгагдан юунд оров?

Хөвүүн миний тухай

Хөндлөнгийн муу хүн

Хөвсөргөн муу үгийг

Хөнөөн салгаж байна

Хан эцэг минь, бид хоёр юу гэж хэлэлцсэн билээ? Зоргал хоны Улаан болдог гэдэг газар бид хоёр юу гэж хэлэлцсэн билээ?

Хорт могойн хэл

Хооронд минь хутгаж

Хов жив оруулбал

Холдож салалгүй, харин

Хоёр нүүрээр учирч

Хор хөнөөлийг тасалж байя гэж хэлэлцсэнгүй билүү? Одоо хан эцэг минь чи хоёр нүүрээр уулзаж хэлэлцэлгүй юунд хөнөөж эхлэв?

Араат могойн шүд

Амрагийн хооронд орж

Ая эвийг эвдвэл

Ам хэлээр уулзан ярьж

Аливаа учрыг олж байя гэж хэлэлцсэнгүй билүү? Одоо хан эцэг минь чи ам хэлээр уулзан ярилгүй, ангижран юунд салав? Хан эцэг минь. Би цөөн боловч олноос дутахгүй, муу боловч сайнаас дордохгүй (Чамд нөхөр түшиг болж байсан). Хоёр аралтай тэрэгний нэгэн арал хугарвал, үхэр түүнийг чирч чадахгүй. Тэр мэт нэгэн арал чинь би биш билүү? Эрт өдөр Хурчахус буйруг хан эцгийн дөчин хөвүүний ах гэж чи хан болсон билээ. Чи хан болоод Тай-Төмөр тайж, Буха Төмөр хоёр дүүгээ алав. Бас чиний дүү Эрх хар алагдахаас айж дутаан, найманы Инанча Билгээ ханд очиж амь хоргодов. Дүү нараа алав гэж Гүр хан авга чинь чамтай байлдахаар ирэхэд чи зуун хүн авч арай гэж амь гарч

Сэлэнгэ рүү дутааж, Хараун хавчил гэдэг газар шургаж чи. Жич мэргидийн Тогтоад Ужаур үжин охиноо бялдуучлан өгч, Хараун хавчлаас гараад Есүхэй хан эцэгт минь ирж: "Авга Гүр хаанаас улсы минь аварч өг" гэж гуйсанд, Есүхэй хан эцэг минь чиний улсыг аварч өгөхийн тулд тайчуудын Хунан Бахажи хоёроор удирдуулан цэрэг засан мордуулж, Гурван Тэл гэдэг газар байгаа Гүр ханыг (дарж түүнийг дөнгөж) хорь гучин хүний хамт Хашин (тангуд) оронд дутаалгаж, чиний улсыг аварч өгсөн билээ. Тэр цагт чи Туул голын хар шугуйд Есүхэй хан эцэгтэй анд бололцоод Ван хан эцэг чиний баясч хэлсэн нь: "Энэ хүргэсэн тусы чинь ургийн ураг хүртэл (мартахгүй) ачийг хариулахыг тэнгэр газрын ивээл мэдтүгэй" гэж биширч хэлсэн билээ. Түүний хойно (чиний дүү) Эрх-хар, найманы Инанча Билгээ хаанаас цэрэг гүйж аваад чамтай байлдахаар ирэхэд чи улсаа орхиж, цөөн хүнтэй амь хоргодон дутааж, хар хятадын Гүр ханыг Сартуулын нутаг Чүй мөрөнд байхад хүрч очоод тэнд нэгэн жил бололгүй бас Гүр хаанаас салж, Уйгур нутаг ба Тангуд газраар тэнэж, таван ямаа шөрөглөн сааж, тэмээний цус ханаж идсээр ганц сохор халиун морьтой хүрч ирэв чи.

Есүхэй хан эцэг минь, чамайг ингэж ядарч явааг сонсож урьд анд бололцооноо сэтгэж, Тахай, Сүхэхэй хоёрыг элч болгож угтуулсан ба би өөрөө Хэрлэн мөрний Бүрги эргээс угтан мордож, Гүсээр нуурт бид золголдов. Чамайг ядаж ирэв гэж гувчуур татаж өгсөн ба урьд эцэгтэй минь анд бололцсон ёсоор Туул голын Хар шугуйд бид хоёр эцэг хөвүүн бололцсон биш билүү? Тэгээд тэр өвөл чамайг бид хүрэн дотроо оруулж

тэжээв. Тэр өвөл өвөлжиж зун өнгөрөөд намар нь мэргидийн Тогтоа бэхийг байлдахаар мордож, Хадиглиг нурууны Муруч сүүл гэдэг газар хатгалдаж, Тогтоа бэхийг Баргужин төхүмийн зүг хөөж, мэргид иргэнийг эзлэн, адуу мал, орд гэр ба хүнс тариа хүртэл цөмийг авч энэ бүгдийг би хан эцэг чамд өгсөн билээ.

Өлсөх өдөр чинь

Өршөөж тэжээсэн би

Өнчрөх сард чинь

Өмөглөж тэтгэсэн би

Бас бид Гүчүгүдийн Буйруг ханыг улуг таг (уул)-ын Сохог ус гэдэг газраар Алтайг давуулан хөөж, Үрүнгү гол хүргэж, Хишилбаши нуурт түүнийг барьж сөнөөв. Тэндээс харьж ирэхэд найманы Хүгсэү сабраг баатар, Байдраг голын билчирт цэргээ засаж, (байлдахаар тосч байсан ажээ. Бид хоёр мөн байлдахаар цэргээ засаж иртэл) нэгэнт үдэш болсон тул маргааш байлдья гэж засацгааж хоновол хан эцэг минь, чи буусан газраа олон гал түлж орхиод мөн шөнө Харсүүл голыг өгсөн хөдлөв.

Бид маргааш өглөө нь үзвэл, чи буусан газраа үгүй болсон тул "Биднийг энэ орхисон гал мэт хаясан ажээ" гэж бид хөдөлж, Эдэр Алтайн билчрээр гэтэлж, Саарь хээр гэдэг газар очиж буув. Тэнд чамайг Хүгсэү сабраг баатар нэхэж очоод Сэнгүмийн эм хөвүүд ба эд хөрөнгө, албат ардыг цөм булаан авч, хан эцэг чамайг Тэлээтү амсар гэдэг газар байх үед нэхэн байлдаж, зарим албат иргэн ба адуу малыг булаан авав. Чамайг дагаж явсан мэргидийн Тогтоагийн хөвүүн Худу, Чулуун хоёр, тэр жавшааныг тохиолдуулж, албат иргэнээ авч эцэгтээ нийлэхээр Баргужин төхүмийн зүг дутаан хөдлөв. Тэр цагт чи: "Найманы Хүгсэү сабрагт эд хөрөнгө ба

албат иргэдээ булаагдав. Хөвүүн минь дөрвөн хүлэг баатраа явуулж тусална уу" гэж гуйсанд, би чам шиг ийм санаа агуулалгүй, даруй Боорчи, Мухулай, Борохул, Чулуун дөрвөн хүлэг баатраа цэргийн хамт илгээсэн билээ. Миний дөрвөн хүлэг баатар очихын урьд Улаан хос гэдэг газар Сэнгүм байлдаж байгаад мориныхоо гуяыг шархдуулж баригдахад хүрч байтал, миний дөрвөн хүлэг баатар хүрэлцэн очиж Сэнгүмийг авраад албат хөрөнгө ба эм, хөвүүд сэлтийг аварч өгөв. Тэр цагт хан эцэг чи биширч үгүүлрүүн: "Хөвүүн Тэмүжин дөрвөн хүлэг баатраа явуулж, миний алдагдан барсан улсыг аварч өгөв" гэж хэлсэн билээ.

Одоо хан эцэг минь, би ямар хэрэгт буруудах, чиний хилэнг хүргэв. Ингэж буруушаан хилэгнэсэн учраа Хубари-хури, Итүргэн хоёр элчийг томилон ирүүлж хэлтүгэй. Энэ хоёрыг эс явуулбал ондоо хүнийг илгээвч болно гэж илгээв⁴⁵ гэжээ. Бичлэгийн өнгө аяс, арга хэлбэр нь дуртгал тэмдэглэлийн шинжтэй гэдгийг өмнө хэлсэн. Архай Хасар, Сүхэхэй Жэсүн хоёрыг элчээр довтолгон ингэж хэлүүлэхэд нь:

178§ Ван хан энэ үгийг сонсоод үгүүлрүүн: "Ай халаг,

Сайн хөвүүнээсээ салж

Сайхан төрөө гутаав би

Эрхэм хөвүүнээс хагацаж

Эвдрэх үйлийг хийв би" гэж гэмшиж үгүүлрүүн: "Одоо хөвүүн (Тэмүжин)-ээ үзэж муу сэтгэвэл энэ мэт цусаа урсгая" гэж андгайлж, чигчий хурууныхаа өндгийг хутгаар хатгаж, цусыг цувируулж аваад өчүүхэн саванд хийж "Хөвүүнд минь өг" гэж илгээв⁴⁶ гэжээ. Энэ бол "Юм мэдээ" гэж үзэх бүрэн үндэстэй юм. "Эртний хүмүүс эд юмсыг харилцан илгээж, тэдгээрийн утгыг тайлж харилцдаг байжээ. Түүнийг бид юм мэдээ гэж нэрлэж байна"⁴⁷

хэмээн доктор Л. Норовсүрэн тодорхойлжээ.

Ван хан Тоорил муу хүний хатгаасанд орж Чингисийг гомдоосондоо ихэд харамсаж өндөгний цусыг савируулж аваад өчүүхэн саванд хийж "Хөвүүнд минь өг" гэж хариу илгээж байгаа нь ахиад ингэхгүй, цусаараа тангараг тавья гэсэнтэй адил утгатай ажээ. Өөрөөр хэлбэл халуун цусаараа харилцаж байгаа нь юм мэдээний хэлбэртэй байгаа юм. "Монголын нууц товчоо"-нд цааш нь

179§ "Бас Чингис хаан Жамуха андад хэлүүлсэн нь: "Хартай муу сэтгэлээр хан эцгээс минь хагацуулав чи. Бид хоёрын хэн эрт боссон нь хан эцгийн хөх хундгаар (айраг) уух бүлгээ. Ямагт би урьд босч уудаг байсан тул чи атаархсан биз. Одоо чи хан эцгийн хөх хундгаар чадах чинээгээрээ уугтун. Чи хэдийхэн хороох вэ" гэж илгээв. (Чингис бага насанд Ван ханы гэрт байснаа дурдаж байгаа бололтой). Бас Чингис хаан Алтан, Хучар хоёрт хэлүүлсэн нь: "Та хоёр намайг тэвчиж шууд урвах гэвүү? Мэхлэн урвах гэв үү? Хучар намайг Нэгүн тайжийн хөвүүн тул "Чи хан бол" гэж бидний хэлэхэд чи хан эс болов. Алтан чиний эцэг Хутула хан, бид бүхнийг захирч явахад чи мэдэлцэж байсан тул Алтан чамайг хан бол гэвэл, чи бас зөвшөөрсөнгүй. Бардан баатрын хөвүүдээс ахмад үеийн хүмүүс болох тул Сача Тайчу хоёрыг хан бол гэж ядав би (Тэр хоёр бас зөвшөөрсөнгүй). Та нарын аль нь ч хан болохгүй тул би та нарт хан өргөмжлөгдөөд захирч явав. Таныг хан болсон бол би

Өрсөх дайн болоход
Өмнө нь уулгалан яваад
Өндөр хөх тэнгэрийн
Өршөөл ивээлд орж
Өстөн дайсныг дарвал

Өнгөтэй сайн охидыг авчирч
Өөдтэй сайн морьдыг олзолж
Өндөр эзэн тандаа барих бүлгээ.
Ойн гөрөөсийг авлах цагт
Ойртуулж шахаж өгөх билээ
Хадын гөрөөсийг авлах цагт
Хавьтуулж шахаж өгөх билээ
Гууны гөрөөсийг авлах цагт
Гуагыг нийлтэл шахаж өгөх билээ
Хээрийн гөрөөсийг авлах цагт
Хээлийг нийлтэл шахаж өгөх билээ

Одоо та нар хан эцэгт минь үнэнчээр нөхөрлөж явтугай. Та нарыг буцаамтгай гэдэг билээ. Битгий дахин урваж одогтун. Та нар Чаутхури (Чингист Алтан улсын Вангин чансангийн өгсөн цол. Энэ тухай 134 дүгээр зүйлд үз)-ийн садан энэ ажээ гэж бүү хэлүүлэгтүн. Гурван мөрний эхэнд бусдыг бүү нутаглуултугай гэж илгээв⁴⁸ хэмээжээ. Өмнөх 178 дугаар зүйлийн адил хүргэж буй мэдээллийнхээ агуулгыг гүнзгийгээр эгшиглэнтэй илэрхийлэхийн тулд хүрнэл ба шүлгийн хэлбэрийн аль алийг ашиглан элч нарт ягштал цээжлүүлэн илгээсэн байна.

180§ Бас Чингис хаан Тоорил дүүдээ үгүүл гэж үгүүлрүүн: "Чамайг дүү гэсний учир нь урьд нэгэн цагт Тумбинай, Чархай Лянхуа хоёр, байлдаанд яваад Огда гэдэг боолыг барьж ирсэн билээ. Огда боолын хөвүүн Хөхөчү-хирсаан, Хөхөчү-хирсааны хөвүүн Ехэй-хонтагар бүлгээ. Ехэй-хонтагарын хөвүүн Тоорил чи, хэний улсыг эзлэх санаатай тэгж бялдуучлан явна? Миний улсыг Алтан Хучар хоёр хэнд ч мэдүүлэхгүй нь лавтай биз. Иймийн тул чамайг дүү гэж нэрийднэ.

Элэнцийн үеийн
Иштэй боол чамд
Эрхэмлэж хэлэх үг минь
Энэ байна
Хуланцын үеийн

Хувьтай боол чамд
Хуурмаггүй хэлэх үг минь
Энэ байна гэж илгээв⁴⁹ гэжээ
Энэ зүйлд Архай Хасар, Сүхэхэй хоёрт энэ үгсийг цээжлүүлж илгээв гэж онцлон тодотгосон байна. "Монголын нууц товчоо"-нд Архай Хасар хаан ахынхаа элч зардсаар нэг бус удаа томилогдон зарагдаж байна. "Монголын нууц товчоо"-ны 183 дугаар зүйлд Хасар өөрийн эм ба гурван хөвүүнээ Ван ханы хүрээнд орхиод Чингисийг эрж Хараун жидуны нуруугаар эрж хайж, шар шөрмөс идэж явсаар сая Чингис хаанд ирж нийлдэг. Хасарыг үзсэн Чингис хаан баясаж Ван ханд дахин элч явуулахаар зөвлөлдөж Жауридайн Халиудар, урианханы Чахурхан хоёрыг томилж Ван хан эцэгт Хасарын үг гэж хэл гэж үгүүлрүүн:

Хасар би танаас салж
Хан ахаа санаж
Хайн эрэвч
Харагдах бараагүй
Сонсдох чимээгүй
Хаана одсоныг мэдэхгүй
Од харан хонож
Орвон дэрлэн унтаж (Гэргүй хонож, дэргүй унтаж) байна.

Миний эм хөвүүд хан эцэг чиний тэнд бий. Хэрэв итгэмжтэй хүнийг илгээвэл би хан эцэгт одох билээ⁵⁰ хэмээн хэлүүлдэг тухай, түүнийг сонсоод Ван хан "Тийм бол Хасар иртүгэй. Итгэмжит хүнд Итүргэнийг илгээе" хэмээн хариу хэлүүлж буй тухай мөн зохиолын 184 дүгээр зүйлд өгүүлдэг билээ.

Энэ цаг үеийн элч нар бол эдүгээ цагийн Элчин сайдууд юм. Эзэндээ, хаандаа чин үнэнч, зарлигийг ёсчлон дагаж биелүүлдэг, туйлын өндөр хариуцлагатай итгэлтэй албат нар нь байжээ. Сүн улсын цэргийн жанжин Хун Мэн гэдэг хүн XIII зууны эхээр

Монголд зорчсон тухай тэмдэглэлдээ "Эзэн нь ямар нэг тушаал буулгах, гэрээ хэлцэл хийхдээ зөвхөн элч илгээдэг. Харин илгээсэн зүйлээ мартахгүйн тулд болхи тэмдэглэгээ хийдэг байв. Элч нь дамжуулсан үгийг ганц ч үгийн зөрөөгүй илтгэдэг бөгөөд энэ нь тэдний том уламжлал юм"⁵¹ хэмээн тэмдэглэжээ.

"Монголын нууц товчоо"-нд гарч буй дээрх аман илгээлтүүдээс, тэрчлэн тухайн цаг үед Монголд зорчиж байсан Хун Мэний бичиж үлдээсэн тэмдэглэл зэргээс үзэхэд XII-XIII зуунд элч мэдээ нь түгээмэл дэлгэрсэн мэдээллийн хэлбэр байсан байна. Элч зарж мэдээ мэдээлэл хүргүүлж буй тухай "Монголын нууц товчоо"-нд олонтаа давтагдан гарч байгаа нь үүнийг батална.

"Монголын нууц товчоо"-ны 169 дүгээр зүйлд "Тийнхүү барих гэж хэлэлцэж тогтсоныг Алтаны дүү Их-Чэрэн гэртээ ирж үгүүлрүүн: "маргааш өглөө Тэмүжинг барихаар шийдэв. Энэ үгийг хүргэсэн хүнд Тэмүжин юугаа ч хайрлахгүй өгөх биз" гэвэл түүний эм Алахачит үгүүлрүүн: "Чиний энэ дэлэм үг, алд хэл чинь юун болно? Хүн сонсож үнэмшүүзэй" гэв. Энэ үгийг сүү хүргэхээр ирсэн тэдний адууч Бадай сонсож буцав. Бадай харьж ирээд нөхөр адууч Хишилигт Чэрэнгийн үгийг хэлбэл Хишилиг үгүүлрүүн: "Би бас очиж учрыг мэдье" гэж Чэрэнгийн гэрт очвол Чэрэнгийн хөвүүн Нарийн-гэгээн, гадна сууж сумаа зүлгэж байна. Нарийн-гэгээн үгүүлрүүн: "Манайхан сая юу гэж ярьсан бэ? Хэлээ татаж, амаа барьж яваасай" гэжээ. Тэгээд Нарийн-гэгээн бас адууч Хишилигт үгүүлрүүн: "Мэргидийн цагаан, ам цагаан хоёр морийг барьж авчир. Уяж хоноод өглөө эрт мордоно" гэжээ. Хишилиг ирж Бадайд үгүүлрүүн: "Тугаар (сая)-ын чинь хэлсэн үнэн

болов. Одоо бид хоёр Тэмүжинд хэл хүргэе" гэж үг барилдаж, мэргидийн цагаан, ам цагаан хоёр морийг барьж, их гэрийн гадна уяад мөн үдэш хонинд орж нэгэн хурга алаад исэр (ор)-ээ түлж чанаад мэргидийн цагаан, ам цагаан хээр хоёр бэлэн уясан морийг унаж тэр шөнөдөө Чингис хаанд давхиж ирэв. Бадай, Хишилиг хоёр Чингисийн гэрийн араас Их-Чэрэнгийн үгүүлсэн үг ба түүний хөвүүн Нарийн гэгээний сумаа зүлгэж бэлдэж байсан хийгээд мэргидийн цагаан, ам цагаан хээр хоёр морийг барьж уя гэсэн бүх үгийг Чингис хаанд хэлж өгөв. Бас Бадай, Хишилиг хоёр үгүүлрүүн: Чингис хаан соёрхвол, бидний үгэнд эргэлзэх явдалгүй. Хамран ирж таныг барья гэж хэлэлцэж тогтсон нь магадтай үнэн гэв⁵² хэмээн гардаг.

Энэ бол аман тэгэхдээ үнэн мэдээ юм. Чингис хаан Их-Чэрэнгийн адуучин сайн санаат Бадай, Хишилиг хоёрын үгэнд итгэж, тэр шөнөдөө багтан итгэлт нөхөддөө хэл мэдээ хүргүүлээд өөрсдөө юм хүмээ орхин суусан газраас зайлан оддог билээ. Амь аварч ачлал хүргэсэн Бадай, Хишилиг хоёрыг сүүлд Чингис хаан "Улстөрийг байгуулалцсан урьдын гавьяат нөхдөө угсаатан ноёд болгож, мятралгүй миний хайрт нөхдийг мянганы ноёд өргөмжилж, соёрхлын үгийг хэлье" гэж зарлиг буулган мянганы ноён болгож байгаа тухай "Монголын нууц товчоо"-ны 202 дугаар зүйлд гардаг. Энэ нь үнэн бодит мэдээллийн үнэ цэнийг өргөж үнэнч сайн нөхдийнхөө итгэлд их хааны

зүгээс хариу барьсан том үнэлгээ, эзэнт төрийн хишиг соёрхол юм.

Үнэн бодитой болсон үйл явдлыг үлгэр домог, туульсын хэлбэрт оруулж дүрсэлсэн хэсэг "Монголын нууц товчоо"-нд нэг бус байгааг сэтгүүл зүйн судлаачид тэмдэглэсэн байдаг. Жишээ нь доктор профессор Л. Норовсүрэн "Монголын нууц товчоо" нийтлэлийн дурсгал болох нь" хэмээх өгүүлэлдээ "Монголын нууц товчоо"-ны 121 дүгээр зүйлд Бөртэ үжиний зөвлөсөн ёсоор Чингисийн хүрээнийхэн Жамухаас салж нүүсний араас баарин омгийн

Хорчи нар гүйцэн ирж Хорчи үгүүлрүүн: "Бид Бодон-чар богдын барьж авсан эмээс төрсөн тул Жамухтай хэвэл нэгтэй, хэлхээ бэхтэй хүмүүс билээ. Иймийн тул Жамухаас хагацаж болохгүй. Гэвч заарин тэнгэр ирж нүдэнд минь зааж үзүүлсэн нь, ухааг-

«
Аман зохиол бол бичгийн нийтлэлийн эхлэл цэг, угшил үндэс, уг сурвалж нь билээ. Дэлхийн улс орнуудын ард түмэн бүр өөрийн гэсэн өвөрмөц аман зохиолын хосгүй нандин өвийг урлан бүтээжээ. Тэдгээрийн нэг нь Монголын ард түмэн юм

»

чин үнээ ирж Жамухыг тойрон явж, Жамухыг ба гэр тэргий нь мөргөсөөр өрөөсөн эврээ хугалж солжир эвэртэй болоод "Эврий минь өг" гэж Жамухын зүг мөөрч шороо сацлан байна. Бас нэгэн мухар ухаа үхрийг их гэрт тэргэнд хөллөжээ. Тэр үхэр их тэргүүр (зам)-ээр Тэмүжиний хойноос зүтгэн явж мөөрөн хэлэх нь:

"Тэнгэр газар эелдэж (зөвлөж)

Тэмүжинг улсын эзэн болтугай" гэж Тээж хүргэж явна" гэж мөөрнө.

Ийнхүү миний нүдэнд заарин тэнгэр ирж зааж үзүүлэв гэж байгаа нь нэн эртний бөө мөргөлийн үеэс үүдэлтэй үлгэрийн санаа зохиомжийг ашигласны жишээ болно.

Мөн Добу мэргэнийг үхсэний хойно Алунгуа эхээс гурван хөвүүн төрснийг Бэлгүнүтэй, Бүгүнүтэй хоёр ах нь ихэд сэжиглэн хэлэлцэж байгааг Алунгуа мэдээд "Шөнө бүр цагаан шар хүн гэрийн өрх тотгоор гийгүүлэн орж ирээд миний хэвлийг илэхэд түүний гэрэл миний хэвэлд шингэх бөлгөө. Тэр хүн, гарах нар, сарны хилээр шар нохой мэт шарвалзсаар гарч одно..." (Н. Т. 21-р зүйл) гэж байгаа нь цэвэр үлгэрийн өгүүлэмж байна...

Мөн Жамуха Найманы Таян ханд хүчит Хасарын эр чадлын тухай өгүүлсэн шүлэглэлд:

Хоромсого саадагтай хүнийг

Ховх татаад залгихад

Хомхой тэр Хасарын

Хоолойд тордоггүй гэнэ (Н. Т. 195-р зүйл) гэх мэтээр хэлсэн нь туульсын баатрын дүрийг санагдуулж байдаг⁵³ гэжээ.

Аман зохиол бол бичгийн нийтлэлийн эхлэл цэг, угшил үндэс, уг сурвалж нь билээ. Дэлхийн улс орнуудын ард түмэн бүр өөрийн гэсэн өвөрмөц аман зохиолын хосгүй нандин өвийг урлан бүтээжээ. Тэдгээрийн нэг нь Монголын ард түмэн юм. Монголын ард түмний үүх түүхийг мөнхлөн үлдээхэд чиглэсэн утга соёлын гайхамшигт өв аман зохиол нь үүсч төлөвшин улам бүр боловсронгуй болж хөгжих явцдаа үлгэр, домог, тууль, ерөөл, магтаал, оньсого, уран хэллэг, дуу шүлэг, зүйр цэцэн үг зэрэг яруу хэллэгийн олон төрөл зүйлийг бүтээж буй болгожээ. Эсгий туургатны хувьд эдгээр уран хэллэгүүд, ялангуяа үлгэр домогууд нь агуулга ач холбогдлоороо ч бичлэгийн арга зохиомжоороо ч өнөө үеийн нийтлэлийн эх ундарга нь болж өгсөн байдаг. Үйл явдал, үнэн бодит байдлыг үлгэрийн хэлбэрт оруулж дүрслэн харуулах, тэдгээрт гарч байгаа

ан амьтан, араатан жигүүртэн, ядуу зүдүү хүмүүсийг төлөөлүүлж жишээлбэл нусгай бор хүүгийн дүрээр эрэлхэг үйлсийг бүтээлгэж шударга ариун ёсыг номлон бусдад сургаал, сургамж болгох зорилгыг агуулсан үлгэр Монголд хэдэн арав зуугаараа бий.

Домогт ч мөн ялгаагүй. Алив домог өнгөрсөн үед хамааралтай байдаг боловч түүхэн үнэнийг өгүүлдгээрээ танин мэдэхүйн чухал ач холбогдолтой юм. Домгийн "Хэлбэр агуулга нь цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн ухамсрын өсөлтийг тусган өөрчлөгдөж ирсэн байна. Энэ хоёр шинж нь домгийг нийтлэлийн эх үндэс гэж үзэх үзлийг лавшруулж байгаа юм.

Домог нь уг удмын, түүхт явдлын, аж байдлын, уул усны гэхчлэн ямар ч хэв шинжтэй байлаа гэсэн ямагт үнэн түүхт явдлыг өгүүлдгээрээ орчин үеийн нийтлэлийн язгуур зарчмыг санагдуулж байдаг. Өөрөөр хэлбэл домог анх үүссэн цагаасаа л байгаль, нийгмийн бодит үзэгдлийг нэхэн дурсах хэлбэрээр тусгаж иржээ. Монгол домог овгийн байгууллын задралын үеэс эхтэй бөгөөд уг удмын домог анх үсчээ. Цаашлаад нийгмийн амьдралд тохиолдсон үнэн явдлыг зохиогчийн уран сэтгэмжээр чимэглэсэн түүхт явдлын домог гарсан байна" гэж⁵⁴ доктор Л. Норовсүрэн тэмдэглэжээ.

Үлгэр домгийн энэхүү уламжлалыг "Монголын нууц товчоо"-г зохиогч маш чадмагаар ашигласан байдаг билээ. Нэмж ганц нэг жишээ баримтыг иш татахад:

"Монголын нууц товчоо"-ны 61 дүгээр зүйлд "Есүхэй баатар, Тэмүжинг өсөн настай байхад Өзлүн эхийн төрхөм олхуноуд иргэнд хөвүүний нагац нараас охин гуйя гэж Тэмүжинг аваад одов. Явах замд Цэгцэр Чихургу

гэдэг газрын хооронд Хонгирадын Дэй сэцэнтэй уулзав.⁵⁵ хэмээн гардаг билээ.

Хэрэг зоригоо асуулцаж мэдэлцэ-ний дараа Дэй сэцэн "Энэ хөвүүн чинь нүдэндээ галтай, нүүртээ гэрэлтэй хөвүүн байна" гэж үнэлээд "Есүхэй худ, би энэ шөнө, нэгэн зүүд зүүдлэв. Цагаан шонхор шувуу, нар сар хоёрыг атган нисч ирээд миний гар дээр буув" гэж зүүдлэв. Нар сарыг бид нүдээр үздэг билээ. Гэтэл нар сарыг шонхор шувуу атгаж миний гар дээр буух нь гайхалтай, ямар сайн тохиол учрах болов гэж бусдад хэлсэн бүлгээ. Есүхэй худ чи, хөвүүн дагуулж ирсэн нь даруй миний зүүдний тайлбар болов. Юун зүүд байх вэ! Танай хиад аймгийн сүлд ирж, зүүдээр дохиолсон ажээ.

Манай хонгирад хэдийнээс бусдын нутаг ба хүнийг булааж тэмцэлддэггүй.

Харь улсыг үл довтлон
Хацар сайт охидоо
Хасаг тэргэнд суулгаж
Хар буур хөллөж
Хатируулж одож
Хаан болсон та нарын
Хатан сууринд дэвшүүлж
Хамт суулгана.
Өөр иргэнийг үл тэмцэн
Өлжгэтэй (суудалтай) тэргэнд суул-
гаж

Өл буур хөллөж
Үүсгэж одож
Өндөр суурь эзлэгчдийн
Өрөөл хань болгоно.

Манай хонгирад хэдийнээс хацар гуа хатадтай, өнгө сайн охидтой тул эзэгийн зүсээр, охидын өнгөөр явна⁵⁶ хэмээн "Монголын нууц товчоо"-ны 63-64 дүгээр зүйлд өгүүлдэг.

Тэрчлэн "Монголын нууц товчоо"-ны 149 дүгээр зүйлд эзэн Чингис хаан өрлөг зургаан жанжинтайгаа хамт ан авд мордож "Шар дэвсгэр дээр гарч бараа харья" гээд толбот бор

мориныхоо дэл шанхан дээр ташуураа тулж унтаад нэг зүүд зүүдлэв. Чингис хаан сэрээд зургаан сайддаа ирж зарлиг болруун:

"Бор зүрх минь
Бол бол хийв.
Богино хавирга минь
Шир шир хийв.
Болшгүй дайсан
Ирэх нь бололтой
Өндөр уулын цаадах
Өргөн шар талд
Гурван хар тугтай
Гурван зуун дайсан байна
Гурван зуун дайсны
Хошууч баатар нь
Зээр морио унаж
Зэвт сумаа дэлж
Бат хуягаа өмсч
Баруун тийш ширвэж
Зүүн тийш ажиглаж
Зүү мэт жирвэлзэж
Утас мэт улалзаж явна.

Энэ зүүд минь үнэн бол зургаан сайд минь та нар яах вэ?"⁵⁷ гэж асуув хэмээн гардаг билээ. Зургаан сайд нь хаан эзэндээ үнэнчээ андгайлаад Шигихутуг Шар дэвсгэрт хүрч шалгаж сайтар харвал бараан тугийг хийсгэсэн балмад дайсны цэрэг бачмаг гэнэт тулгарч эзэн хааны зүүд үнэн болох нь батлагддаг.

Энд гарч буй Дэй сэцэний болоод Чингис хааны зүүд нь бүгд үнэн бодит үндэслэлтэй бөгөөд "Монголын нууц товчоо"-г зохиогч тэдгээрийг үлгэр домог, зөн совингийн хэлбэрт оруулан зохиомжилж уран гоёмсог дүрслэн үзүүлжээ. Үүнийг үлгэр домгийн хэлбэрээр зохиомжилсон нийтлэл бичиг гэж үзэх учиртай. Ийм зохиомжлолоор элбэг баян бүтээл бол чухамхүү "Монголын нууц товчоо" яах аргагүй мөн.

"Монголын нууц товчоо"-ны 124 дүгээр зүйлд их эзэн Чингис хаан Архай Хасар, Тахар, Сүхэхэй, Чаурхан дөрвийг "Холыг холбогч, ойрын оторч болтугай" хэмээн соёрхсоныг өмнө дурдсан. Академич Ц. Дамдинсүрэн гуай үүнийг хөрвүүлж тайлбарлахдаа "Хол ойрыг сурвалжлах газарч" гэжээ. Илгэхлээр яриангүй мэдээ мэдээлэлтэй холбоотой ойлголт болох нь тодорхой байгаа юм.

"Монголын нууц товчоо"-ны 281 дүгээр зүйлд "Өгэдэй хаан үгүүлрүүн: "Эцгийнхээ их сууринд сууж, хаан эцгээс хойш үйлдсэн хэрэг минь: Нэгдүгээрт, би Алтан улсыг эзлэн дагуулав. Хоёдугаарт, бидний хооронд элч явуулж харилцах ба элдэв хэргийг зөөлгөх өртөө замыг тавиулав. Гуравдугаарт, усгүй газарт худаг малтуулж гаргуулаад улс иргэнийг ус өвсөнд хүрэлцээтэй болгов. Дөрөвдүгээр, зүг зүгийн суурин улсын хотуудад мэдээлэгч, захирагч нарыг тавьж, улс иргэнийг хөл хөсөр, гар газар тавиулж, амар түвшин болгов. Хаан эцгээс хойш энэ дөрвөн үйлийг нэмэв би..."⁵⁸

"Монголын нууц товчоо"-ны 271 дүгээр зүйлд "Бас Өгэдэй хаан, Цагадай ахад зөвлөж илгээсэн нь: "Би Чингис хаан эцгийнхээ бэлэн сууринд суув. Ямар эрдмээр хаан суув? гэж би хэлэгдэх бишүү? Цагадай ахыг зөвшөөрвөл бидний хаан эцгийн эзэлж дуусгаагүй орхисон Хятад улсын Алтан хааныг эзлэхээр мориль гэж зөвлөж илгээвэл, Цагадай ах зөвшөөрч "Юу алзах вэ? Аураг ордоо сайн хүнд тушаагаад морилогтун. Би эндээс цэрэг гаргаж илгээе" гэжээ. Их ордоо Олдхар Хорчид тушаав"⁶⁰ гэж гардаг билээ.

Эндээс харахад Өгэдэй хаан эцгийнхээ их үйлийг нэр төртэй үргэлжлүүлэхийг ямагт эрмэлзэж сэтгэл ихэд

шаналж байсан нь мэдрэгддэг. Туулай жилийн хавар буюу 1231 онд Өгэдэй хаан хятад иргэнд морилж Хятадын цэргийг хиартал хядаж, улмаар өрнө зүгт их аян дайныг явуулж хаан эцгийн үйл хэргийг залгамжлан үргэлжлүүлээд эцгийнхээ их сууринд сууж үйлдсэн дөрвөн сайн үйлсийнхээ талаар сүүлд нэхэн дурсаж өгүүлэхдээ улс хооронд элч явуулж харилцах, элдэв хэргийг зөөлгөх өртөө замыг тавиулснаа, мөн тэрчлэн зүг зүгийн суурин улсын хотуудад мэдээлэгч, захирагч нарыг тавьж, улс иргэнийг хөл хөсөр, гар газар тавиулж амар түвшин болгосноо онцлон дурдаж байна.

Эзэнт Монгол Улс өртөө улааг байгуулснаар хүн төрөлхтөний түүхэнд өрнө дорныг холбосон харилцаа холбооны цоо шинэ сүлжээг үүсгэн буй болгож, Элчин төлөөлөгчдийг ийш тийш нь илгээж улс хоорондын нэн чухал мэдээ мэдээллийн солилцоог үүсгэж, тэдгээр мэдээллийг зөөгч нарт хүндэтгэлтэй хандахыг шаардан "Их засаг"-аар хуульчлан баталгаажуулж улмаар практикт хэвшүүлснээр дипломат харилцааны цоо шинэ номлолыг хөгжүүлж боловсронгуй болгосон нь бодит үнэн юм. Энэ нь хүн төрөлхтөн, дэлхийн улс орнуудын хооронд харилцаа холбоо, мэдээллийн үр ашигтай систем үүсч хөгжих эхлэл нь болсон байна. Үүнийг "Монголын нууц товчоо"-нд "Холыг холбогч, ойрын оторч", "Элч явуулж харилцах ба элдэв хэргийг зөөлгөх", "Зүг зүгийн суурин улсын хотуудад мэдээлэгч, захирагч нарыг тавьж", "улс иргэнийг хөл хөсөр, гар газар тавиулж, амар түвшин болгов" гэх зэрэг нэр томъёогоор бичиж тэмдэглэж үлдээжээ.

"Монголын нууц товчоо"-нд эзэнт Монгол Улс үүсч бүрэлдэж төлөвшсөн түүхэн цаг үеийн аугаа их баатарлаг

үйл явдлуудыг үнэн бодитойгоор хураангуйлан өгүүлжээ. Үйл явдлуудыг түүхэн он цагийн дэс дарааллыг алдагдуулалгүйгээр хянамгайгаар хүүрнэн буулгажээ. "Их хуралдаан болж, хулгана жилийн (1240) хуран (долдугаар) сард Хэрлэний Хөдөө арлын Долоон болдог, Шилхэнцэг хоёрын завсар хааны орд бууж байхад бичиж төгсөв" хэмээн зохиогч "Монголын нууц товчоо"-г дуусгаснаас ч энэ зарчим нь тов тодорхой харагдана. "Монголын нууц товчоо"-ны эцсийн буюу 282 дугаар зүйлд өгүүлсэн 21 үгтэй эл ганц өгүүлбэр нь ч өөрөө сэтгүүл зүйн бичлэгийн номын мэдээний тэмдэглэлт бичлэгийн хэлбэрийг өдрийн тэмдэглэлийн өнгө аястай хослуулжээ. Эл өгүүлбэр өөртөө "Монголын нууц товчоо"-г хэзээ, хаана, юу болж байхад бичиж дуусав гэсэн чухал мэдээллийг агуулж байна.

Тэмдэглэл бол монголчуудын хувьд маш эртний уламжлалтай бичлэгийн өндөр соёл бөгөөд улс орон, нийгэм, ард түмний улстер, аж ахуйн амьдралд юу болж өнгөрөв, юу болж байна гэдгийг тод томруунаар бичиж үлдээх боломжтой торгомсог тансаг бичлэг юм. Тэмдэглэлд уран дүрслэлийн болоод задлан шинжлэл бүхий бодол бясалгалын аргыг ч хослуулан хэрэглэж болдог. Мэдээлсэн, тэмдэглэсэн, шүүмжилсэн, эргэн дурссан, эргэцүүлэн бясалгасан бүх өнгө аяс тэмдэглэлд байдаг. "Аливаа хэрэг явдлыг тэмдэглэж бичсэн дэвтэр"-ийг тэмдэглэл гэдэг хэмээн "Монгол хэлний товч тайлбар толь"-д тайлбарласан нь бий. Энэ үүднээс хандах юм бол "Монголын нууц товчоо"-нд тэмдэглэл хэмээх бичлэгийг санагдуулахуйц, эл бичлэгийн элементүүд ямар нэг байдлаар шингэжээ гэж үзэж болохоор мөр бадаг, хүүрнэлүүд

сэтгүүл зүйн бусад төрөл, зүйлээсээ илүү элбэг баян байна. Дээр дурдсан бүхнийг нэгтгэн базаж дүгнэбэл:

1. "Монголын нууц товчоо" нь 12 дэвтэр, 282 зүйлээс бүрдсэн монголчуудын үнэн амьдралын тухай түүх юм (Жинхэнэ эхээс гээгдэж хаягдсан хэсгүүд байхыг үгүйсгэхгүй, учир нь Лувсанданзангийн "Алтан товч", Рашид Эддиний "Монголын түүх", Чингисийн Цэдиг зэрэг бусад зохиолд "Монголын нууц товчоо"-ны жинхэнэ эхэд байсан болов уу гэж үзэж болох хэсэг, мөр, бадаг цөөнгүй бий). Зохиомжийн хэлбэр нь хүүрнэн өгүүлэх нийтлэлийн шинжтэй аж. Уран дүрслэлт зураглал, тэмдэглэл, домог туульсын шинжтэй хэсгүүд, зүйр цэцэн үгс, яруу тансаг шүлэглэлээр чимэглэн баяжуулж утга агуулгыг улам гүнзгийрүүлжээ. Гэхдээ энэ нь тухайн цаг үед болж өнгөрсөн үйл явдлууд, түүхэн чухал бодит баримтуудын мөн чанарыг бүдгэрүүлсэнгүй.

"Монголын нууц товчоо"-нд XII зууны сүүлч, XIII зууны эхэн үеийн Монголын эзэнт гүрний үүсэл, хөгжил, төлөвшил, цэцэглэн мандалтын үеийн он жилүүдийн үнэн бодит түүхийг өгүүлэн хүүрнэж буй, сэтгүүл зүй нь зөвхөн үнэн бодит байдлын толь болж үлддэг тул "Монголын нууц товчоо"-г нийтлэлийн хосгүй ховорхон дурсгалт бичиг мөн гэж үзэж болохоор байна.

2. "Монголын нууц товчоо"-ны бичлэгийн арга хэлбэр, зохиомж нь уран зохиолын гэхээсээ илүүтэйгээр нийтлэлийн өнгө төрхтэй, товч тодорхойг чухалчлан эрхэмлэжээ. Түүний 282 дугаар зүйлд хэдэн арван хуудас үргэлжилсэн нэг ч хэсэг алга. Сэтгүүл зүйн бичлэгүүд нь үнэнийг өгүүлэх үндсэн зарчмаараа төдийгүй товч тодорхойг эрхэмлэсэн хэмжээ хэмнэл, нягт хураангуйн шаардлагаараа уран

зохиолын өгүүлэл, тууж, роман зэрэг төрлөөс онцгойрон ялгардаг билээ.

"Монголын нууц товчоо"-нд сэтгүүл зүйн бичлэгт хамааруулж болох мэдээ, сурвалжлага, сурвалжилсан тэмдэглэл, ярилцлага, дуртгал тэмдэглэл, тэдгээрийн шинж тэмдгийг өөртөө агуулсан бичлэгийн элементүүд бодитой байна. Энэ нь "Монголын нууц товчоо"-г нийтлэлийн дурсгалт бичиг мөн гэж үзэх өөр нэг үндэслэлийг бүрдүүлж өгч байгаа болно.

"Монголын нууц товчоо" бол Монголын эзэнт гүрэн, эзэн Чингис хааны болоод тухайн цаг үеийн монголчуудын үнэн бодит амьдралыг баримт нотолгоотойгоор үнэмшилтэй бөгөөд уран яруугаар өгүүлэн хүүрнэсэн нийтлэлийн дурсгалт бичиг мөн.

Ишлэл

- ¹ 2010. Монголын шилдэг нийтлэл. Хорлоогийн Цэвэлээ. 59 дүгээр боть. Уран бүтээл, намтар дуртгал. УБ., 119 дэх тал.
- ² Дурд. зох., 122 дахь тал.
- ³ Дурд. зох., 123 дахь тал.
- ⁴ 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 11 дэх тал.
- ⁵ 2010. Монголын шилдэг нийтлэл. Хорлоогийн Цэвэлээ. 59 дүгээр боть. Уран бүтээл, намтар дуртгал. УБ., 123-124 дэх тал.
- ⁶ 2009. Монголын нууц товчоо. "Болор судар" хэвлэлийн газар. УБ., 135 дахь тал.
- ⁷ Дурд. зох., 124 дэх тал.
- ⁸ 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 164 дэх тал.
- ⁹ 2009. Монголын нууц товчоо. "Болор судар" хэвлэлийн газар. УБ., 193 дахь тал.
- ¹⁰ 2010. Монголын шилдэг нийтлэл. Хорлоогийн Цэвэлээ. 59 дүгээр боть. Уран бүтээл, намтар дуртгал. УБ., 125 дахь тал.
- ¹¹ 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 47 дахь тал.
- ¹² Дурд. зох., 78 дахь тал.
- ¹³ 2010. Монголын шилдэг нийтлэл. Хорлоогийн Цэвэлээ. 59 дүгээр боть. Уран бүтээл, намтар дуртгал. УБ., 127 дахь тал.
- ¹⁴ Дурд. зох., 127 дахь тал.

¹⁵ Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ., 87 дахь тал.

¹⁶ 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 28-29 дэх тал.

¹⁷ 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 131 дэх тал.

¹⁸ 2010. Монголын шилдэг нийтлэл. Хорлоогийн Цэвэлээ. 59 дүгээр боть. Уран бүтээл, намтар дуртгал. УБ., 131-132 дахь тал.

¹⁹ Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ., 279 дахь тал.

²⁰ 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 210 дахь тал.

²¹ Дурд. зох., 25 дахь тал.

²² Дурд. зох., 220 дахь тал.

²³ Дурд. зох., 231 дэх тал.

²⁴ 2010. Монголын шилдэг нийтлэл. Хорлоогийн Цэвэлээ. 59 дүгээр боть. Уран бүтээл, намтар дуртгал. УБ., 135 дахь тал.

²⁵ 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 36 дахь тал.

²⁶ 2010. Монголын шилдэг нийтлэл. Хорлоогийн Цэвэлээ. 59 дүгээр боть. Уран бүтээл, намтар дуртгал. УБ. // Т. Баасансүрэн. Өмнөх үг. 8 дахь тал.

²⁷ Норовсүрэн Л. 2013. Сэтгүүл зүйн онол, түүхийн асуудлууд. УБ., 141 дэх тал.

²⁸ Дурд. зох., 144 дэх тал.

²⁹ Дурд. зох., 141 дэх тал.

³⁰ Дурд. зох., 143 дахь тал.

³¹ Норовсүрэн Л. 2013. Сэтгүүл зүйн онол, түүхийн асуудлууд. УБ., 143 дэх тал.

³² Дурд. зох., 139 дэх тал.

³³ Дурд. зох., 139 дэх тал.

³⁴ Дурд. зох., 145 дахь тал.

³⁵ 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 25-26 дахь тал.

³⁶ Дурд. зох., 69 дэх тал.

³⁷ Дурд. зох., 168 дахь тал.

³⁸ Дурд. зох., 176 дахь тал.

³⁹ 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 181 дэх тал.

⁴⁰ Дурд. зох., 194 дэх тал.

⁴¹ Дурд. зох., 195 дахь тал.

⁴² Дурд. зох., 78 дахь тал.

⁴³ 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 75-76 дахь тал.

⁴⁴ Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ., 25 дахь тал.

⁴⁵ 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 122-125 дахь тал.

⁴⁶ Дурд. зох., 125 дахь тал.

⁴⁷ Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ., 12 дахь тал.

⁴⁸ 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 125-126 дахь тал.

⁴⁹ Дурд. зох., 126-129 дэх тал.

⁵⁰ Дурд. зох., 130 дахь тал.

⁵¹ Хун Мэн. 1975. Полное описание монголо-татар. М., с. 47.

⁵² 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 113-114 дахь тал.

⁵³ Норовсүрэн Л. 2013. Сэтгүүл зүйн онол, түүхийн асуудлууд. УБ., 137-138 дахь тал.

⁵⁴ Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ., 33 дахь тал.

⁵⁵ 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ., 30 дахь тал.

⁵⁶ Дурд. зох., 31 дэх тал.

⁵⁷ Дурд. зох., 90-91 дэх тал.

⁵⁸ Дурд. зох., 237 дахь тал.

⁵⁹ Дурд. зох., 230-235 дахь тал.

⁶⁰ Дурд. зох., 238 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 2009. Монголын нууц товчоо. "Болор судар" хэвлэлийн газар. УБ.

2. 1976. Монголын нууц товчоо. Улсын хэвлэлийн газар. УБ.

3. 2010. Монголын шилдэг нийтлэл. Хорлоогийн Цэвлээ. 59 дүгээр боть. Уран бүтээл, намтар дуртгал. УБ.

4. Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ.

5. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.

6. Норовсүрэн Л. 2013. Сэтгүүл зүйн онол, түүхийн асуудлууд. УБ.

7. Хун Мэн. 1975. Полное описание монголо-татар. М.

Резюме

"Сокровенному сказанию монголов", шедевр монгольской культуры и словесности, были посвящены многочисленные исследования отечественных и зарубежных учёных, которые рассматривали его прежде всего как исторический или литературный памятник. Автор высказывает своё мнение, рассматривая "Сокровенное сказание монголов" с точки зрения публицистики. Так, автор подчёркивает, что в "Сокровенном сказании монголов" нет ни одного вымышленного героя, а названия мест, городов, рек и озёр, упомянутых в произведении, реальны, что даёт возможность причислить его к журналистике. Автор сравнивает предположения, выдвинутые учёными ранее в этой области, в том числе Х.Цэвлээ и Л.Норовсүрэна и, анализируя письменную форму "Сокровенного сказания монголов", приходит к выводу, что данное произведение является неоспоримым памятником монгольской публицистики.